

ТӨВ АЙМГИЙН ЛҮН СУМЫН НУТАГ ДЭВСГЭРТ ОРШИХ АРГАЛ НЭРТЭЙ “АЛТНЫ ҮНДСЭН ОРД АШИГЛАХ” ТӨСЛИЙН БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ

(Хүчин чадал: 3.0 сая.тонн/жил)

БОМТ ТАЙЛАН БОЛОВСРУУЛСАН:

Б.Бат-Эрдэнэ

АЛТГАНА РЕСУРСЕС ХХК-ИЙН
ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРАЛ:

Б.ГАНТУЛГА

УЛААНБААТАР ХОТ
2026

ГАРЧИГ

БҮЛЭГ 1. ТАЙЛАНГИЙН ТЕХНИКИЙН БУС ХУРААНГУЙ	3
БҮЛЭГ 2. ОРШИЛ	5
БҮЛЭГ 3. ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ХҮРЭЭ	9
БҮЛЭГ 1. БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ	18
1.1. Байгаль орчны менежментийн төлөвлөгөөний гол зорилт, түүнийг боловсруулах, хянан батлах, тайлагнах журам	18
1.2. СӨРӨГ НӨЛӨӨЛЛИЙГ БУУРУУЛАХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨ	20
1.3. Техникийн болон биологийн нөхөн сэргээлтийн төлөвлөгөө	37
1.4. Биологийн олон янз байдлыг дүйцүүлэн хамгаалах төлөвлөгөө	37
1.5. НҮҮЛГЭН ШИЛЖҮҮЛЭХ, НӨХӨН ОЛГОВОР ОЛГОХ ТӨЛӨВЛӨГӨӨ	38
1.6. ТҮҮХ СОЁЛЫН ӨВИЙГ ХАМГААЛАХ ТӨЛӨВЛӨГӨӨ	39
1.7. ОСОЛ, ЭРСДЭЛИЙН МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ	40
1.8. ХОГ ХАЯГДЛЫН МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ	41
1.9. ОРЧНЫ ХЯНАЛТ ШИНЖИЛГЭЭНИЙ ХӨТӨЛБӨР	42
1.10. БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ ТҮҮНИЙ ХЭРЭГЖИЛТИЙГ ОРОЛЦОГЧ, СОНИРХОГЧ ТАЛУУДАД ТАЙЛАГНАХ, ХЭЛЭЛЦҮҮЛЭХ ХУВААРЬ	47
1.11. БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ ЗАРДЛЫН НЭГДСЭН ДҮН	48

БҮЛЭГ 1. ТАЙЛАНГИЙН ТЕХНИКИЙН БУС ХУРААНГУЙ

Төв аймгийн Лүн сумын нутаг дахь MV-023049 тоот хайгуулын талбай нь хээрийн бүсэд байрладаг бөгөөд орчны ерөнхий байгаль орчин нь хүний үйл ажиллагааны нөлөө бага, байгалийн хэвийн төлөв байдлаа хадгалсан байна. Судалгаагаар талбайн хөрс нь дунд зэргийн үржил шимтэй боловч гаднын нөлөөнд амархан эвдрэх шинжтэй, тоосжилт үүсэх магадлалтай бөгөөд хүнд металл болон бусад бохирдуулагчийн агууламж стандартын хүлцэх хэмжээнээс даваагүй тул хүний эрүүл мэнд болон байгаль орчинд ноцтой эрсдэл илрээгүй гэж үнэлэгдсэн. [Байгаль орчны төлөв байдлын үнэлгээний тайлан Baseline report-2025](#)

Ургамлын судалгаагаар нийт 86 зүйл ургамал бүртгэгдсэн ба энэ нь тухайн бүсийн экосистем хэвийн, ургамлын төрөл зүйлийн бүрдэл алдагдаагүйг харуулж байна. Гэхдээ Хуурамч хонин арц болон Монгол догар зэрэг хамгаалалт шаардлагатай хоёр зүйл ургамал илэрсэн нь төслийн ажлын нөхцөлөөс хамааран хөндөгдөх эрсдэлтэй бөгөөд шаардлагатай тохиолдолд мэргэжлийн байгууллагын заавраар шилжүүлэн суулгах нь зүйтэй гэж дүгнэв.

Амьтны аймгийн хувьд судалгаагаар халиун бугын нийт 120 орчим бодгаль бүхий сүрэг, Монгол тарвага 7 газарт 37 га талбайд тархсан байдалтай, цагаан зээр улирлын чанартай нүүдэллэн ирдэг нь тогтоогдсон. Эдгээр зүйлс нь төслийн барилга байгууламжийн ажлын дуу чимээ, хөдөлгөөн, амьдрах орчны хязгаарлалтад мэдрэмтгий тул зохистой менежмент шаардлагатай. Шувуудын хувьд нийт 47 зүйл бүртгэгдсэн бөгөөд үүнээс олон улсын ангиллаар “Ховордож болзошгүй” нөмрөг тас, “Эмзэг” зэрэглэлтэй идлэг шонхор зэрэг махчин шувууд илэрч, нийт 6 идэвхтэй үүр бүртгэгдсэн нь төслийн орчинд хамгаалалт шаардлагатай зүйлс оршин тогтнож буйг илэрхийлж байна. Мөн талбайд нэг зүйл гүрвэл болон хоёр зүйл могой тохиолдох ба тэдгээрийн дотор ажилчдын аюулгүй ажиллагаанд анхаарах шаардлагатай хортой могой ч байна.

Уур амьсгалын хувьд талбай нь эрс тэс эх газрын уур амьсгалтай бүсэд хамаарч өвөл нь хүйтэн, зун халуун бөгөөд хур тунадасны ихэнх нь зун ордог. Хаврын улиралд салхи хүчтэй байх нь тоосжилт үүсэх эрсдэлийг нэмэгдүүлдэг. Агаарын чанарын суурь хэмжилтээр SO₂ бага хэмжээгээр илэрсэн нь хайгуулын үеийн техник, дизель генераторын ажиллагаатай холбоотой боловч бусад бохирдуулагч (NO₂, CO) илрээгүй, тоосонцрын хэмжээ стандартын хязгаарт байсан нь байгаль орчны суурь нөхцөл харьцангуй цэвэр байгааг харуулж байна.

Төслийн хэрэгжилтийн үед хөрс хуулалт, барилгын ажил, тээврийн хөдөлгөөнөөс шалтгаалан хөрсний эвдрэл, тоосжилт, амьтдын амьдрах орчны хязгаарлалт, ховор ургамал болон махчин шувуудын үүрэнд үзүүлэх нөлөө зэрэг сөрөг нөлөөлөл үүсэж болзошгүй. Эдгээр нөлөөллийг бууруулахын тулд тоос дарах, шимт хөрсийг тусгаарлан хадгалах, ховор ургамлыг шаардлагатай бол шилжүүлэн суулгах, амьтдын улирлын хөдөлгөөнийг харгалзан ажиллах горим өөрчлөх, махчин шувуудын үүрний орчимд хамгаалалтын бүс тогтоох, хог хаягдлыг ангилан зохистой хадгалах болон жил бүр экологийн мониторинг хийх зэрэг арга хэмжээнүүдийг төлөвлөсөн.

Төслийг хэрэгжүүлэхийн өмнө байгаль орчны нөлөөллийн нарийвчилсан үнэлгээний дүгнэлт, газрын ашиглалтын зөвшөөрөл, ус ашиглах зөвшөөрөл, тэсрэх материалын агуулах болон ашиглалтын зөвшөөрөл зэрэг хуулийн дагуу шаардлагатай бичиг баримтыг

бүрдүүлэх ёстой. Дүгнэж хэлбэл, хайгуулын талбай нь байгалийн хувьд экосистемийн хувьд тогтвортой, төрөл зүйл сайтай боловч хамгаалалт шаардлагатай ургамал, шувуу, хөхтөн амьтдын тархалттай бүс тул төслийн үйл ажиллагааг зөв төлөвлөн хэрэгжүүлж, нөлөөллийг бууруулах арга хэмжээг бүрэн хэрэгжүүлсэн нөхцөлд байгаль орчны тогтвортой байдлыг хадгалах боломжтой гэж үзэж байна.

БҮЛЭГ 2. ОРШИЛ


Энэхүү байгаль орчны нөлөөллийн нарийвчилсан үнэлгээний гол зорилго нь байгаль орчны нөлөөллийн ерөнхий үнэлгээний дүгнэлтэд заасан чиглэл, хуваарийн дагуу Төв аймгийн Лүн сумын нутагт байрлах MV-023049 тоот Аргал нэртэй алтны үндсэн ордыг ашиглах төслийн үйл ажиллагаанаас байгаль орчин, нийгэм, эдийн засагт үзүүлэх эерэг болон сөрөг нөлөөллийг тодорхойлох, хүний эрүүл мэнд, байгаль орчин, эдийн засгийн үр ашигт учруулах эрсдэлийг тодорхойлох, сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээг тодорхойлоход орших юм.

БОННУ-ны хүрээнд гүйцэтгэсэн ажлууд: Байгаль орчны зөвлөх үнэлгээ, зөвлөх үйлчилгээний Эко эстимэйт ХХК-ний судалгааны баг 2024 оны 08 сараас эхлэн Байгаль орчны төлөв байдлын суурь судалгааг гүйцэтгэж ирсэн бөгөөд төслийн талбайд 10 орчим удаагийн давтамжтай судалгааг хийж гүйцэтгэсэн үр дүнг ашигласан. Үүнд:

Агаарын чанарын хэмжилт, орчны дуу чимээний түвшнийг тогтоох хэмжилт, гадаргын болон гүний усны чанарыг үнэлэх дээж, гүний усны түвшин, хөрсний бохирдлыг тогтоох дээж (хүнд металл, агрохими, нийт болон чөлөөт цанид) шинжилгээнүүдийг хийж гүйцэтгэснээс гадна зэрлэг амьтны мониторинг судалгаа хийх зорилгоор 2 ширхэг автомат камерыг байршуулж үр дүнг энэ сард боловсрууллаа (хүснэгт 1).

Хүснэгт 1. 2024-2025 оны хооронд хийж гүйцэтгэсэн дээжлэлт, түүний тоо хэмжээ

№	Ажлын/шинжилгээний төрөл	Хэмжих нэгж, ш	Дээжийн тоо, хэмжээ
1	Гадаргын болон гүний усны хяналт шинжилгээ	ш	3
2	Усны нийт болон чөлөөт цанид	ш	3
3	Гадаргын болон гүний усны ерөнхий шинжилгээ	ш	3
4	Гадаргын болон гүний усны хүнд металлын шинжилгээ	ш	3
5	Хөрсний хяналт шинжилгээ	ш	7
6	Хөрсний ерөнхий үзүүлэлт, ялзмаг	ш	7
7	Хөрсний нийт цанид	ш	3
8	Агаарын чанарын хяналт шинжилгээ	ш	6
9	Тоосны хяналт шинжилгээ	ш	6
10	Орчны дуу чимээний хэмжилт	ш	6
11	Амьтны мониторинг (автомат камер)	ш	2



Зураг 1. Дээж авсан байршил

Хүснэгт 2. Дээж авсан цэгийн байршил, төрөл

№	Өргөрөг	Уртраг	Шинжилгээний төрөл	Байршлын нэр
1	47.95891	104.84338	Агаарын чанар	Байгалийн суурь түвшин тогтоох
2	47.96181	104.94024	Агаарын чанар	Баяжуулах үйлдвэр
3	47.97464	104.93772	Агаарын чанар	Нуруулдан уусгах талбай
4	47.97607	104.94876	Агаарын чанар	Ажилчдын суурин
5	47.97536	104.96213	Агаарын чанар	Зам дагуу
6	48.02737	104.95261	Агаарын чанар	Тэсрэх материалын агуулах
7	48.00661	104.95499	Усны чанар	Хайгуулын кемпийн худаг
8	47.97587	104.95234	Усны чанар	Цэвэршүүлсэн ус
9	47.9935	104.92521	Усны чанар	Малчны гар худаг
10	47.93699	104.94237	Усны чанар	Туул гол
11	47.95891	104.84338	Хөрсний чанар	Байгалийн суурь түвшин тогтоох
12	47.96181	104.94024	Хөрсний чанар	Баяжуулах үйлдвэр
13	47.97464	104.93772	Хөрсний чанар	Нуруулдан уусгах талбай

№	Өргөрөг	Уртраг	Шинжилгээний төрөл	Байршлын нэр
14	47.97348	104.94914	Хөрсний чанар	Ажилчдын суурин
15	47.97142	104.96082	Хөрсний чанар	Хогийн цэг
16	47.97536	104.96213	Хөрсний чанар	Зам дагуу
17	48.02737	104.95261	Хөрсний чанар	Тэсрэх материалын агуулах
18	47.99161	104.9488	Ургамал	Ургамлын төрөл, зүйл, тусгаг бүрхэц
19	47.99967	104.9247	Ургамал	
20	48.0097	104.9211	Ургамал	
21	48.02358	104.946	Ургамал	
22	48.03392	104.9589	Ургамал	
23	48.03744	104.95419	Амьтан	Аргаль, буга, тарвага болон бусад
24	47.98913	104.89682	Амьтан	Буга, цагаан зээр болон бусад

Энэхүү үнэлгээний хүрээнд нийт 19 цэгээс дээж авсан бол 2 байршилд зэрлэг амьтны зурган мэдээлэл цуглуулах зорилгоор 2 ш автомат камер байршуулах замаар тогтмол зурган мэдээллийн сан үүсгэж байна. Агаар болон хөрсний дээжийг баригдаж байгаа болон баригдахаар төлөвлөсөн объект, түүний орчимд сонгосон бол байгалийн суурь түвшнийг тогтоох зорилгоор нөлөөллийн бүсээс хол буюу Их мааньт уулыг баруун зүгт давж сонголоо. Усны чанарын дээжийг Туул гол, малчны гар худаг, хайгуулын болон ажилчдын суурины унд ахуйд хэрэглэж буй худаг, цэвэршүүлэх төхөөрөмжөөс дээжлэлт хийлээ.

Нийгэмд-эдийн засаг, нутгийн оршин суугчдад үзүүлэх нөлөөллийг үнэлэх зорилгоор зорилтот 20 орчим асуулгыг урьдчилан бэлтгэж нөлөөллийн бүсийн 10 гаруй малчин өрхөөс асуулга авч ажиллаа.

Бүс нутгийн буюу ус, хөрсний цацрагийн дэвсгэр түвшнийг тодорхойлох зорилгоор 3 уст цэг, 20 орчим хөрсний дээж авч шинжилгээг хийлгэж тайланд дэлгэрэнгүй тусгалаа.

Мэдээлэл цуглуулах бэлтгэл ажил: Суурин боловсруулалт

Суурин боловсруулалтын үед дараах ажлуудыг хийж гүйцэтгэгдсэн болно. Үүнд:

1. Төслийн талбай орчмын газар нутгийг хамарсан зургийг ArcGIS 10.6 программаар газарзүйн мэдээллийн системд холбож өгсөн.
2. Төслийн техник эдийн засгийн үндэслэл, бусад холбогдох бичиг баримттай нарийвчлан танилцаж хүрээлэн буй орчинд сөрөг нөлөөлөл үзүүлэх эх үүсвэр бүрийн хүчин зүйл, тэдгээрийн шинж чанар зэргийг тодорхойлов.
3. Төслийн үйл ажиллагааны сөрөг нөлөөлөлд өртөх байгаль орчны бүрэлдэхүүн хэсгүүдийг тодорхойлохдоо математик загвар, газарзүйн мэдээллийн системийн аргийг ашиглан тодорхойлов.

4. Төслийн үйл ажиллагаанаас байгаль орчны бүрэлдэхүүн хэсэг тус бүрд үзүүлэх сөрөг нөлөөллийг нэгтгэн үнэлсэн. Нэгтгэсэн үр дүнгээс хүрээлэн буй орчинд үзүүлэх нөлөөллийг эрэмбэлэн гол нөлөөллийг тодорхойлж, түүнийг хэрхэн бууруулах арга хэмжээг Монгол улсын байгаль орчныг хамгаалах хууль, үүнтэй нийцүүлэн гаргасан бусад хууль, эрхзүйн баримт бичигтэй нийцүүлэн боловсруулж цаашид анхаарвал зохих чиглэлд зөвлөмж боловсруулан тайланд тусгалаа.
5. Биологийн олон янз байдлыг дүйцүүлэн хамгаалах талаар 5 чиглэлд ажлыг төлөвлөсөн бөгөөд үүнд Туул голыг хамгаалах төлөвлөгөө, ховор амьтдын тархац, байршил, шилжилт хөдөлгөөнийг хянах зорилгоор сансрын дамжуулагч бүхий хүзүүвч зүүх, уурхайн нөлөөлөлд шууд өртөж болзошгүй монгол тарваганы популяцийг сэлгэн нутагшуулахаас гадна Аргалийн нурууны өвөр хэсэгт 4 орчим га талбайд тархсан хуурамч хонин арц хэмээх ургамлын хамгаалах, сэлгэн нутагшуулах, үржүүлэх туршилт хийх төлөвлөгөөг боловсруулсан.

БҮЛЭГ 3. ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ХҮРЭЭ

Төслийн үйл ажиллагааны явцад байгаль орчин, хүний эрүүл мэндэд үзүүлэх сөрөг нөлөөллөөс сэргийлэхийн тулд дараах хууль, дүрэм журам, стандарт шаардлагыг хангаж, даган мөрдөх зайлшгүй шаардлагатай. Мөн дор дурдсан хууль эрхзүйн баримт бичгүүдэд өөрчлөлт орсон тохиолдолд хамгийн сүүлчийн албан ёсны эх материалыг ашиглах шаардлагатай. Үүнд:

Дагаж мөрдөх хууль:

- Монгол Улсын Үндсэн хууль (1992 оны 1 дүгээр сарын 13-ны өдөр, 2019 оны нэмэлт)
- Байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээний тухай хууль (2012 оны 5 сарын 17-ны шинэчилсэн найруулга, 2017 оны нэмэлт)
- Усны тухай хууль (2012 оны 5 сарын 17, 2020 оны нэмэлт)
- Ус бохирдуулсны төлбөрийн тухай хууль (2012 оны 5 сарын 17, 2019 оны нэмэлт)
- Хог хаягдлын тухай хууль (2017 оны 5 сарын 12, 2020 оны нэмэлт)
- Байгалийн ургамлын тухай хууль (1995 оны 4 дүгээр сарын 11, 2015 оны нэмэлт)
- Байгалийн нөөц ашигласны төлбөрийн тухай хууль (2012 оны 5 сарын 17-ны шинэчилсэн найруулга, 2017 оны нэмэлт)
- Газрын төлбөрийн тухай хууль (1997 оны 04 сарын 24, 2019 оны нэмэлт)
- Байгаль орчныг хамгаалах тухай хууль (1995-03-30, 2019 оны нэмэлт)
- Агаарын тухай хууль (2012 оны 5 сарын 17-ны шинэчилсэн найруулга, 2019 оны нэмэлт)
- Агаарын бохирдлын төлбөрийн тухай хууль (2010-06-24, 2019 оны нэмэлт)
- Амьтны тухай хууль (2012 оны 5 сарын 17-ны шинэчилсэн найруулга, 2017 оны нэмэлт)
- Эрүүгийн хууль (2015 оны 12 сарын 03-ны шинэчилсэн найруулга, 2020 оны нэмэлт)
- Химийн хорт болон аюултай бодисын тухай хууль (2006 оны 5 сарын 25, 2020 оны нэмэлт)
- Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн тухай хууль (2008-05-22, 2018 оны нэмэлт)
- Хөрс хамгаалах, цөлжилтөөс сэргийлэх тухай хууль (2012-05-17, 2015 оны нэмэлт)
- Газрын тухай хууль (2002 оны 6 дугаар сарын 07-ны өдөр, 2019 оны нэмэлт)
- Барилгын тухай хууль (2016 оны 2 дугаар сарын 05-ны шинэчилсэн найруулга, 2020 оны нэмэлт)
- Галын аюулгүй байдлын тухай хууль (2015 оны 7 сарын 28, 2015 оны нэмэлт)
- Гамшгаас хамгаалах тухай хууль (2017 оны 2 сарын 02-ны шинэчилсэн найруулга, 2020 оны нэмэлт)
- Зөрчлийн тухай хууль (2017 оны 05 сарын 11-ний шинэчилсэн найруулга, 2020 оны нэмэлт)

Дараах хүснэгтэд үйл ажиллагааны үед дээр дурдсан хуулиудаас онцгойлон анхааран дагаж мөрдөх заалтуудыг тусгав. Үүнд:

Хүснэгт 3. МУ-ын хуулиудаас онцгойлон анхааран дагаж мөрдөх заалтууд

Хуулийн нэр	Анхаарах заалтууд
Агаарын бохирдлын төлбөрийн тухай хууль (2010 оны 6 дугаар сарын 24)	7 дугаар зүйл. Төлбөрийн хувь, хэмжээ 9 дүгээр зүйл. Төлбөр төлөх, тайлагнах
Байгаль орчныг хамгаалах тухай хууль (1995-03-30, 2019 оны нэмэлт)	21 дүгээр зүйл. Байгаль орчныг бохирдохоос хамгаалах 31 дүгээр зүйл. Аж ахуйн нэгж, байгууллагын үүрэг 49 дүгээр зүйл. Байгаль орчинд учруулсан хохирлыг нөхөн төлөх
Газрын тухай хууль (2002-06-07, 2009 -07-16, 2010 оны нэмэлт)	45 дугаар зүйл. Газар ашиглагчийн эрх, үүрэг 50 дугаар зүйл. Газрыг үр ашигтай, зохистой ашиглах, хамгаалах нийтлэг шаардлага 51 дүгээр зүйл. Газрыг ашиглах эрүүл ахуйн шаардлага 62 дугаар зүйл. Хохирлыг нөхөн төлүүлэх 63 дугаар зүйл. Хууль тогтоомж зөрчигчид хүлээлгэх хариуцлага
Газрын төлбөрийн тухай хууль (1997 оны 04 сарын 24)	3 дугаар зүйл. Газрын төлбөр төлөгч 7 дугаар зүйл. Газрын төлбөрийн хувь хэмжээ 8 дугаар зүйл. Газрын төлбөрөөс чөлөөлөх 9 дүгээр зүйл. Газрын төлбөр ноогдуулах 12 дугаар зүйл. Хариуцлага
Усны тухай хууль (2012 оны 5 сарын 17-ны шинэчилсэн найруулга)	22 дугаар зүйл. Усны нөөцийг хамгаалах 24 дүгээр зүйл. Усны нөөцийг бохирдохоос хамгаалах 25 дугаар зүйл. Ус бохирдуулсны болон хомсдуулсны төлбөр, нөхөн төлбөр тогтоох 28 дугаар зүйл. Ус ашиглагчид олгох зөвшөөрөл 29 дүгээр зүйл. Ус ашиглах гэрээ байгуулах, цуцлах 30 дугаар зүйл. Ус ашиглагчийн үүрэг, ус ашиглагчид тавигдах шаардлага 31 дүгээр зүйл. Ус ашигласны төлбөр 33 дугаар зүйл. Хууль тогтоомж зөрчигчид хүлээлгэх хариуцлага
Байгалийн ургамлын тухай хууль (1995 оны 4 дүгээр сарын 11)	7 дугаар зүйл. Ургамлыг хамгаалах 9 дүгээр зүйл. Ургамлыг нөхөн сэргээх 21 дүгээр зүйл. Хууль тогтоомж зөрчигчид хүлээлгэх хариуцлага
Байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээний тухай хууль (2012 оны 5 сарын 17-ны шинэчилсэн найруулга)	7 дугаар зүйл. Нөлөөллийн үнэлгээ 8 дугаар зүйл. Байгаль орчны нөлөөллийн нарийвчилсан үнэлгээ 9 дүгээр зүйл. Байгаль орчны менежментийн төлөвлөгөө 13 дугаар зүйл. Төсөл, хөтөлбөр хэрэгжүүлэгчийн эрх 14 дүгээр зүйл. Төсөл, хөтөлбөр хэрэгжүүлэгчийн үүрэг 15 дугаар зүйл. Байгаль орчны нөлөөллийн нарийвчилсан үнэлгээ хийх эрх бүхий аж ахуйн нэгжийн эрх 16 дугаар зүйл. Байгаль орчны нөлөөллийн нарийвчилсан үнэлгээ хийх эрх бүхий аж ахуйн нэгжийн үүрэг 18 дугаар зүйл. Нөлөөллийн үнэлгээний үйл ажиллагааны олон нийтийн оролцоо

Хуулийн нэр	Анхаарах заалтууд
Байгалийн нөөц ашигласны төлбөрийн тухай хууль, (2012 оны 5 сарын 17-ны шинэчилсэн найруулга)	19 дүгээр зүйл. Хууль тогтоомж зөрчигчдөд хариуцлага хүлээлгэх
	20 дугаар зүйл. Хохирлыг нөхөн төлүүлэх
	6 дугаар зүйл. Ус, рашааны нөөц ашигласны төлбөр ногдох зүйл
	10 дугаар зүйл. Ус, рашааны нөөц ашигласны төлбөр тооцох үзүүлэлт
	15 дугаар зүйл. Ус, рашааны нөөц ашигласны төлбөрийн хувь, хэмжээ
Хог хаягдлын тухай хууль (2017 оны 5 сарын 12-ны шинэчилсэн найруулга)	20 дугаар зүйл. Усны нөөц ашигласны төлбөрөөс чөлөөлөх, хөнгөлөх
	10 дүгээр зүйл. Хог хаягдлын талаар иргэн, аж ахуйн нэгж, байгууллагын нийтлэг эрх, үүрэг
	15 дүгээр зүйл. Хогийн саванд тавигдах шаардлага
	16 дугаар зүйл. Энгийн хог хаягдал сэргээн ашиглах, дахин боловсруулах, устгах, булшлах
	20 дугаар зүйл. Хог хаягдлын төвлөрсөн цэгт хориглох үйл ажиллагаа
	23 дугаар зүйл. Аюултай хог хаягдлын эх үүсвэр дээр түр хадгалах
	24 дугаар зүйл. Аюултай хог хаягдлыг тээвэрлэх
Гамшгаас хамгаалах тухай хууль (2017 оны 2 сарын 02-ны өдрийн шинэчилсэн найруулга)	33 дугаар зүйл. Аюултай хог хаягдал хадгалахад тавигдах нэмэлт шаардлага
	40 дүгээр зүйл. Хог хаягдлыг эдийн засгийн эргэлтэд оруулах
	43 дугаар зүйл. Хууль тогтоомж зөрчигчид хүлээлгэх хариуцлага
	7 дугаар зүйл. Гамшгийн эрсдэлийг үнэлэх
	8 дугаар зүйл. Гамшгаас хамгаалах үйл ажиллагааг төлөвлөх
Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн тухай хууль (2008-05-22)	9 дүгээр зүйл. Гамшгийн эрсдэлийг бууруулах
	10 дугаар зүйл. Гамшгаас хамгаалах бэлэн байдлыг хангах
	13 дугаар зүйл. Гамшгаас хамгаалах сургалт зохион байгуулах
	34 дүгээр зүйл. Хуулийн этгээдийн эрх, үүрэг
	6 дугаар зүйл. Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн шаардлага, стандарт
	7 дугаар зүйл. Үйлдвэрлэлийн барилга байгууламжид тавих шаардлага
	9 дүгээр зүйл. Машин механизм, тоног төхөөрөмжид тавих шаардлага
	10 дугаар зүйл. Өргөх, зөөх, тээвэрлэх механизмд тавих шаардлага
	12 дугаар зүйл. Химийн хорт ба аюултай бодис, тэсэрч дэлбэрэх бодис, тэсэлгээний хэрэгсэл, цацраг, биологийн идэвхт бодистой харьцахад тавих шаардлага
	13 дугаар зүйл. Галын аюулгүй байдалд тавих шаардлага

Хуулийн нэр	Анхаарах заалтууд
	17 дугаар зүйл. Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн болон мэргэжлийн сургалт
	26 дугаар зүйл. Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн арга хэмжээний санхүүжилт
	27 дугаар зүйл. Аж ахуйн нэгж, байгууллагын хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн зохион байгуулалт
	28 дугаар зүйл. Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн талаар ажил олгогчийн эрх, үүрэг
	29 дүгээр зүйл. Үйлдвэрлэлийн осол, хурц хордлогын үед авах арга хэмжээ
	31 дугаар зүйл. Ажлын байрны хөдөлмөрийн нөхцөлийн үнэлгээ
	32 дугаар зүйл. Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн талаарх хууль тогтоомжийн биелэлтэд тавих хяналт
	36 дугаар зүйл. Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн тухай хууль тогтоомж зөрчигчдөд хүлээлгэх хариуцлага

Дагаж мөрдөх дүрэм, журам:

- БОАЖ-ын сайдын 2018 оны 11 сарын 19 -ны өдрийн А/444 тушаал .“ Энгийн хог хаягдал цуглуулах, тээвэрлэх, дахин боловсруулах , сэргээн ашиглах, устгах, булшлах үйл ажиллагаа эрхлэгчийг бүртгэх маягт”, “Энгийн хог хаягдал цуглуулах , тээвэрлэх, дахин боловсруулах, сэргээн ашиглах, шатаах, устгах, булшлах үйл ажиллагааны тайлангийн маягт”
- БОАЖ-ын сайд, Сангийн сайдын хамтарсан 2018 оны 11-р сарын 13-ны өдрийн А-429/257 тушаал “Үүсэх хог хаягдлыг үйлдвэрлэгч болон импортлогч хариуцах зарим бүтээгдэхүүний жагсаалт”
- БОАЖ-ын сайдын 2017 оны 12-р сарын 12-ны өдрийн А/349 тушаал “Эх үүсвэрээс гарах хог хаягдлын кодчилсон жагсаалт, тэдгээрийн зэрэглэл”
- БОАЖ-ын сайдын 2018 оны 11 сарын 12-ны өдрийн А/428 тушаал “ Хог хаягдлын улсын мэдээллийн нэгдсэн сангийн тогтолцоо, бүрдэл болон мэдээлэл төвлөрүүлэх журам”
- БОАЖ-ны сайдын 2018 оны 01 сарын 30-ны өдрийн А/18 дугаар тушаалын 1 дүгээр хавсралт Аюултай хог хаягдлыг тээвэрлэх, цуглуулах, хадгалах, дахин боловсруулах, устгах, экспортлох үйл ажиллагаа эрхлэх аж ахуйн нэгж, байгууллагад зөвшөөрөл олгоход тавигдах шаардлага болон зөвшөөрөл олгох журам”
- Нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн хурлын 2020 оны 2 дугаар сарын 20-ны өдрийн 32/03 дугаар тогтоолоор баталсан “Энгийн хог хаягдлыг цэвэрлэх, ангилал, цуглуулах, тээвэрлэх, дахин боловсруулах, сэргээн ашиглах, устгах, булшлах журам”
- БОАЖ-ын сайд, ГХ-ны сайдын хамтарсан 2009 оны 334/104 тушаал “Химийн хорт болон аюултай бодис экспортлох, импортлох, хил дамжуулан тээвэрлэх болон үйлдвэрлэх худалдах журам” (2020 оны 2 сарын 10-ны өдөр нэмэлт өөрчлөлт орсон)
- БОНХАЖ-ын сайд, ЭМС-ын сайдын хамтарсан тушаал. "Химийн хорт болон аюултай бодисын ангилал батлах тухай" 2015.10.08 №А/356/396
- Химийн Хорт Болон Аюултай Бодисын Бодлого Зохицуулалтын Асуудал Эрхэлсэн Үндэсний Зөвлөлийн тогтоол. (2008.03.23, №1): Химийн хорт бодисын осолтой холбогдуулан авч хэрэгжүүлэх зарим арга хэмжээний тухай.
- БОАЖ-ын сайдын 2019 оны 10 сарын 29-ны өдрийн А/618 дугаар тушаал “Байгаль орчны менежментийн төлөвлөгөө боловсруулах, хянан батлах, тайлагнах журам” –ын дараах зүйлийг даган мөрдөж ажиллана.

- Тухайн жилийн байгаль орчны менежментийн төлөвлөгөөг боловсруулах
- Тухайн жилийн байгаль орчны менежментийн төлөвлөгөөний биелэлтийг тайлагнах
- Түлш, эрчим хүчний сайдын 2007 оны 12 дугаар сарын 04-ний өдрийн 93 дугаар тушаалын хавсралт Даралтат савыг төхөөрөмжлөх, аюулгүй ашиглах дүрэм
- Монгол Улсын шадар сайд, БОАЖ-ын сайд, ЭМ-ийн сайдын хамтарсан тушаал 2017.05.23 дугаар: 54/А/136/А/215. Химийн хорт болон аюултай бодис хадгалах, тээвэрлэх, ашиглах, устгах журам
- Химийн хорт болон аюултай бодисыг хадгалах, тээвэрлэх, ашиглахад тавигдах шаардлага
- Химийн хорт болон аюултай бодисыг хадгалахад тавих нэмэлт шаардлага
- Химийн хорт болон аюултай бодисыг тээвэрлэхэд тавих нэмэлт шаардлага
- Химийн хорт болон аюултай бодисыг ашиглахад тавих нэмэлт шаардлага
- Химийн хорт болон аюултай бодис устгахад тавигдах шаардлага
- БОАЖ, ЭМ сайдын 2009 оны 51/75 дугаар хамтарсан тушаал “Усны сан бүхий газрын онцгой болон энгийн хамгаалалтын бүс, ус хангамжийн эх үүсвэрийн эрүүл ахуйн бүсийн дэглэм”-ийн дараах зүйлийг даган мөрдөж ажиллана.
- Энгийн хамгаалалтын бүс ба түүний дэглэм
- Усны эх үүсвэрийн эрүүл ахуйн бүс ба түүний дэглэм
- Зам, тээврийн сайдын 2013 оны 10 дугаар сарын 21-ны өдрийн 232 дугаар тушаалын нэгдүгээр хавсралт Авто тээврийн хэрэгслийн техникийн хяналтын үзлэг явуулах журам

Дагаж мөрдөх стандарт:

Хүснэгт 4. Төслийн үйл ажиллагаанд хамааралтай нийгэм, байгаль орчин, эрүүл мэнд, аюулгүй ажиллагааны стандартууд

Стандартын нэр	Дугаар
Аж ахуй нэгж, байгууллага, барилга байгууламжид гал унтраах анхан шатны багаж хэрэгслийн зайлшгүй байх шаардлага, норм	MNS 5566. : 2020
Агаарт байх бохирдуулах бодисын хүлцэх хэмжээ. Техникийн ерөнхий шаардлага	MNS 5885:2008
Агаарын чанар. Техникийн ерөнхий шаардлага	MNS 4585:2025
Амьсгалын замыг хамгаалах хэрэгсэл. (Хошуувч, шүүлтүүртэй баг, тусгаарласан агаартай бүтэн баг)	MNS 5620 : 2006
Агаарын чанарын нийтлэг асуудал. Нарийн ширхэгтэй тоосыг тодорхойлох арга	MNS 5365:2004
Агаарын чанар - Хот суурин газрын гадаад орчны агаарт байх бохирдуулах бодисын хүлцэх хэм хэмжээ	MNS 6063 : 2010
Ажлын байрны агаар. Ажлын байрны агаарын урсгалын хурдыг хэмжих арга	MNS 5077 : 2001
Ажлын байрны агаар. Ажлын байрны агаарын температур, чийгийг хэмжих арга.	MNS 5387 : 2004
Агаар мандал. Агаарын бохирдуулах бодисыг тодорхойлох аргад тавигдах ерөнхий шаардлага.	MNS 3113:1981
Агуулахын барилга	БНБД 31-19-10, 2010

Стандартын нэр	Дугаар
Ахуйн хог хаягдлыг тээвэрлэхэд тавих ерөнхий шаардлага	MNS 5344:2011
Автомашинны дизель хөдөлгүүрийг утааны тортгийн шүүлтүүр (DPF)-ээр тоноглох, ашиглах. Техникийн ерөнхий шаардлага	MNS 6757 : 2019
Аюултай ачаа. Ангилал. Тээвэрлэлтэд тавих ерөнхий шаардлага	MNS 4978 : 2017
Авто тээврийн хэрэгслийн техникийн байдалд тавих ерөнхий шаардлага	MNS 4598:2011
Авто тээврийн хэрэгслийн техникийн хяналтын үзлэг хийх заавар. Ерөнхий шаардлага	MNS 5011:2003
Авто тээврийн хөдлөх бүрэлдэхүүний эргономикийн үзүүлэлтүүд	MNS 4599:2003
Байгаль орчны хамгааллын стандартын систем. Үндсэн дүрэм	MNS 0017-0-0-06:79
Байгаль орчин. Эвдэрсэн газрын нөхөн сэргээлт. Нэр томьёо, тодорхойлолт	MNS 5914 : 2008
Барилга байгууламжийн галын аюулгүй байдал	БНБД 21-01-02
Байгаль хамгаалал. Хөрс. Хот суурин газрын хөрсний эрүүл ахуйн аюулгүйн үзүүлэлт бохирдлыг үнэлэх.	MNS 3297-2019
Байгаль хамгаалал. Хөрс. Шинжилгээний дээж авахад тавигдах ерөнхий шаардлагууд	MNS 3298 : 1991
Байгаль орчин. Газар шорооны ажлын үед үржил шимт хөрс хуулалт , хадгалалт	MNS 5916 : 2008
Байгаль орчин. Эвдэрсэн газрыг ургамалжуулах. Техникийн ерөнхий шаардлага	MNS 5918 : 2008
Байгаль орчныг хамгаалах. Агаар мандал. Дотоод шаталтат хөдөлгүүрээс гарах агаар мандлыг бохирдуулах хорт бодис. Нэр томьёо, тодорхойлолт.	MNS 17-2-1-01 : 1978
Байгаль орчин. Усны чанар. Дээж авах. 5-р хэсэг: Ундны ус, хүнс болон ундаа үйлдвэрлэхэд хэрэглэгдэх уснаас дээж авах заавар	MNS ISO 5667-5 : 2001
Барилгын гаднах ажлын байрны гэрэлтүүлэг. Техникийн шаардлага	MNS 6845 : 2020
Бохир ус зайлуулах цэг тогтоох. Ерөнхий шаардлага	MNS 6230 : 2010
Бензин хөдөлгүүртэй автомашин. Утааны найрлага дах хорт бодисын зөвшөөрөгдөх дээд хэмжээ ба хэмжих арга	MNS 5013:2009
Гамшгийн үе дэх аюулгүй байдал. Барилга, байгууламжийн инженерийн системийн удирдлага болон мониторингийн бүтэц, зохион байгуулалтын тогтолцоо. Ерөнхий шаардлага	MNS 6566 : 2015
Галын аюулгүй байдал. Техникийн шаардлага	MNS 4244:1994
Галын аюулаас хамгаалах нийтлэг асуудал. Галын ангилал	MNS 4284 : 2017
Галын аюултай бүтээгдэхүүний ангилал, зэрэглэл	MNS 4999 : 2000
Дизель хөдөлгүүртэй автомашин – Утааны тортогжилтын зөвшөөрөгдөх дээд хэмжээ ба хэмжих арга	MNS 5014:2009
Дээж авах, савлах, тээвэрлэх, хадгалах журам,	MNS 2305-94
Натрийн шингэн шил (Натрийн силикатын уусмал). Техникийн шаардлага	MNS GOST 13078:2017
Толгой хамгаалах хэрэгсэл-сонсголын эрхтэн хамгаалах хэрэгсэл (бөглөө, чихэвч)-техникийн ерөнхий шаардлага	MNS 5388 : 2004

Стандартын нэр	Дугаар
Толгой хамгаалах хэрэгсэл-Нүд хамгаалах хэрэгсэл-Нүдний шил. Техникийн ерөнхий шаардлага	MNS 5389 : 2004
Толгой хамгаалах хэрэгсэл-Дуулга	MNS 5621 : 2006
Толгой хамгаалах хэрэгсэл. Нүүрэвч	MNS 5624 : 2006
Усны чанар. Дээж авах. 7 дугаар хэсэг: Уурын зуухны ус болон уураас дээж авах заавар	MNS ISO 5667-7 : 2001
Уурын ба ус халаах зуух, даралтат сав — 1 дүгээр хэсэг: Гүйцэтгэлийн шаардлага	MNS ISO 16528-1:2019
Усан орчны чанарын үзүүлэлт. Ерөнхий шаардлага	MNS4586-1998
Хамгаалалтын бээлий. Ерөнхий шаардлага	MNS 5622 : 2011
Хөлийн хамгаалалт Ажлын тусгай гутал	MNS 5623 : 2006
Хөдөлмөрийн аюулгүй ажиллагаа, эрүүл ахуй. Үйлдвэрлэлийн үйл ажиллагаанд тавих ерөнхий шаардлага	MNS 4968: 2000
Хөдөлмөрийн аюулгүй ажиллагаа, эрүүл ахуй, сургалтын зохион байгуулалт, үндсэн дүрэм.	MNS 4969 : 2000
Хөдөлмөрийн аюулгүй ажиллагаа, эрүүл ахуй. Өргөх зөөх ачааны массын зөвшөөрөгдөх дээд хэмжээ	MNS 4970 : 2000
Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл мэнд Хөдөлмөрийн эрүүл ахуй. Ажлын байрны орчин. Эрүүл ахуйн шаардлага	MNS 4990. : 2015
Хөдөлмөрийн аюулгүй ажиллагаа, эрүүл ахуй. Химийн хорт бодисын ангилал ба аюулгүй ажиллагааны ерөнхий шаардлага	MNS 4992:2000
Хөдөлмөрийн аюулгүй ажиллагаа эрүүл ахуй. Хамгаалалтын хувцас. Ерөнхий шаардлага.	MNS ISO 13688:2000
Хөдөлмөрийн аюулгүй ажиллагаа, эрүүл ахуй. Химийн хорт болон аюултай бодисын шошго, анхааруулах тэмдэг	MNS 5029 : 2011
Хөдөлмөрийн аюулгүй байдал. Үйлдвэрлэлийн эрүүл ахуй. Үйлдвэрийн барилгын салхивч, агааржуулалтын системд тавих ерөнхий шаардлага	MNS 5078 : 2001
Хөдөлмөрийн аюулгүй байдал. Үйлдвэрийн эрүүл ахуй. Ачих, буулгах ажлын аюулгүй ажиллагааны ерөнхий шаардлага	MNS 5079 : 2001
Хөдөлмөрийн аюулгүй байдал. Үйлдвэрлэлийн эрүүл ахуй. Эрүүл ахуйн хамгаалалтын бүсийн хэмжээ, ерөнхий шаардлага	MNS 5105 : 2001
Хөдөлмөрийн аюулгүй ажиллагаа, эрүүл ахуй. Цахилгааны галын аюулгүй байдал. Ерөнхий шаардлага.	MNS 5390 : 2004
Хөдөлмөр хамгааллын систем Галын аюулгүй байдал Ерөнхий шаардлага	MNS 4244 : 1994
Хөдөлмөр хамгаалал. Аюулгүй ажиллагааны тэмдэг ба дохионы өнгө	MNS 4643 : 1998
Хөдөлмөрийн хамгаалах хэрэгсэлд тавих ерөнхий шаардлага	MNS 4931:2000
Хөдөлмөрийн аюулгүй ажиллагаа, эрүүл ахуй. Ажлын байрны агаар дахь тоосны агуулгыг хэмжихэд тавигдах ерөнхий шаардлага.	MNS 5010 : 2001
Хөдөлмөрийн аюулгүй байдал. Үйлдвэрлэлийн эрүүл ахуй. Цахилгааны аюулгүй ажиллагаа. Хүрэх хүчдэл ба гүйдлийн зөвшөөрөх дээд түвшин	MNS 5145 : 2002
Хөдөлмөрийн аюулгүй байдал Үйлдвэрлэлийн эрүүл ахуй. Цахилгааны аюулгүй байдал Хамгаалах газардуулга, тэглэлт	MNS 5146 : 2002

Стандартын нэр	Дугаар
Хөдөлмөрийн аюулгүй байдал Үйлдвэрлэлийн эрүүл ахуй. Цахилгааны аюулгүй ажиллагаа Ерөнхий шаардлага	MNS 5150-2002
Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуй. Ажлын байран дахь гэрэлтүүлгийн хэмжилт, зөвшөөрөх хэмжээнд тавих ерөнхий шаардлага	MNS 6767 : 2019
Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуй. Ажлын байран дахь шуугианы өртөлтийн хэмжилт, зөвшөөрөх дээд хэмжээ, ажилтны сонголт хамгаалахад тавих ерөнхий шаардлага	MNS 6768. : 2019
Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуй. Механик доргион - Ажлын багаж төхөөрөмжөөс ажилтны гарт дамжих доргионы өртөлтийн хэмжилт, зөвшөөрөх дээд хэмжээнд тавих ерөнхий шаардлага	MNS 6769 : 2019
Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуй. Механик доргион - Ажилтны бүх биед дамжих доргионы өртөлтийн хэмжилт, зөвшөөрөх дээд хэмжээнд тавих ерөнхий шаардлага	MNS 6770 : 2019
Хөдөлмөрийн аюулгүй ажиллагаа эрүүл ахуй. Химийн хорт болон аюултай бодис, бүтээгдэхүүний агуулах. Ерөнхий шаардлага	MNS 6458: 2014
Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл мэнд. Хөдөлмөрийн эрүүл ахуй. Ажлын байрны агаараас нийт тоосны сорьц цуглуулах, шинжлэх арга	MNS 6656 : 2017
Хөдөлмөр хамгаалал Автомашины техникийн үйлчилгээ, засвар Аюулгүй ажиллагааны ерөнхий шаардлага	MNS 13-3-004 : 1983
Хөрс. Дээж авах, савлах, тээвэрлэх, хадгалах журам.	MNS 2305 : 1995
Хөрсний чанар. Хөрсөнд агуулагдах бохирдуулах бодисын зөвшөөрөгдөх дээд хэмжээ	MNS 5850:2019.
Хүрээлэн буй орчин. Эрүүл мэндийг хамгаалах. Аюулгүй байдал. Ундны ус. Эрүүл ахуйн шаардлага, чанар, аюулгүй байдлын үнэлгээ	MNS0900:2018
Хүрээлэн байгаа орчин. Усны чанар. Хаягдал ус. Ерөнхий шаардлага	MNS 4943 : 2015
Шуугианаас хамгаалах хэрэгсэл ба аргууд. Ангилал.	MNS 12-4-005 : 1985
Эрүүл мэндийн технологи. Химийн бодисын хордлогын онцгой байдлын үеийн хурдавчилсан оношилгоо. Анхны тусламж үзүүлэх	MNS 6460:2014

- Засгийн газрын 2019 оны 108-р тогтоолоор батлагдсан “Барилга байгууламжийн зураг төсөл боловсруулах, магадлал хийх дүрэм”
- Засгийн газрын 2021 оны 212-р тогтоолоор батлагдсан “ Барилга байгууламжийг ашиглалтад оруулах дүрэм”
- Засгийн газрын 2021 оны 213 дугаар тогтоол, Барилгын ажлыг эхлүүлэх, үргэлжлүүлэх, ашиглалтад оруулах дүрэм
- Усны барилга байгууламжийн зураг төслийн ажлын жишиг норм (БД 81-106-11)
- Усны барилга, байгууламжийн зураг төсөл зохиох үндсэн журам (БНБД 33-01-03)
- Усны барилга байгууламжийн ажлын төсвийн суурь норм (БНБД 81-33-10)
- Амьтны аймгийн тухай хууль (2012)

Энэ хуулиар газар, ус, хөрсөнд байгалийн жамаараа амьдардаг, Монгол улсын нутаг дэвсгэр дэх унаган, нутагшсан болон нүүдлийн амьтдыг хамгаалах, өсгөн үржүүлэхтэй холбогдсон харилцааг зохицуулна. Монгол улсын нэгдэн орсон олон улсын гэрээнд энэ хуульд зааснаас өөрөөр заасан бол олон улсын гэрээний заалтыг дагаж мөрдөнө.

- Байгаль орчныг хамгаалах тухай хууль (1995)

Энэ хууль нь хүний эрүүл, аюулгүй орчинд амьдрах эрхийг хангах, нийгэм, эдийн засгийн хөгжлийг байгаль орчны тэнцэлтэй уялдуулах, өнөө болон ирээдүйн үеийнхний ашиг сонирхлын үүднээс байгаль орчныг хамгаалах, түүний баялгийг зохистой ашиглах, жам ёсны боломжтойг нь нөхөн сэргээхтэй холбогдож төр, иргэн, аж ахуй нэгж байгууллагын хооронд үүсэх харилцааг зохицуулахад оршино.

Монгол улсын нэгдэн орсон конвенц:

- Зэрлэг амьтан, ургамлын аймгийн ховордсон зүйлийг олон улсын хэмжээнд худалдаалах тухай конвенц (1995) – Convention on International Trade in Endangered Species of Wild Fauna and Flora (CITES).

- Биологийн төрөл зүйлийн тухай НҮБ-ын 1992 оны конвенц (1993) – Convention on Biodiversity (CBD).

- Олон улсын ач холбогдол бүхий ус, намгархаг газар, ялангуяа усны шувууд олноороо амьдардаг орчны тухай конвенц (1997)- Ramsar convention (Рамсар).

- Зэрлэг амьтдын нүүдлийн зүйлийг хамгаалах тухай Бонын конвенц (1991)- Convention on Migratory Species (CMS).

Стандарт:

- MNS 6735:2018 “Уулархаг нутгийн зам, замын байгууламжийн нүүдлийн зэрлэг амьтдад зориулсан гарц
- MNS 6515:2015 “Тал хээр, говь цөлийн бүсийн авто болон төмөр замын дагуу зэрлэг амьтдад зориулсан гарц”
- MNS 6942:2021. “Аэродром орчимд агаарын хөлгийг шувуу, мал, амьтантай мөргөлдөх аюулаас сэргийлэх”
- MNS 6518:2015 Өндөр хүчдэлд шувуу цохиулж эрсдэхээс урьдчилан сэргийлэх

Цацрагийн дэвсгэр түвшний судалгааны тайланд ашигласан Монгол улсын стандартууд:

1. MNS 5632:2006. Цацрагийн хамгаалалт. Усан дахь радоны хэмжээг тодорхойлох гамма спектрометрийн арга;
2. MNS 5626:2006. Цацрагийн хамгаалалт. Лабораторийн гамма спектрометрийн арга;
3. MNS 5630:2006. Цацрагийн хамгаалалт. Гадаргын бохирдолтын байж болох хэмжээ;
4. MNS 5631:2006. Цацрагийн хамгаалалт. Цөмийн цацрагийн тунгийн зөвшөөрөгдөх хэмжээ;

MNS0900:2018. Ундны ус, Эрүүл ахуйн шаардлага, чанар, аюулгүй байдлын үнэлгээ

БҮЛЭГ 1. БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ

1.1. Байгаль орчны менежментийн төлөвлөгөөний гол зорилт, түүнийг боловсруулах, хянан батлах, тайлагнах журам

Алтгана Ресурсес ХХК нь Төв аймгийн Лүн сумын Өгөөмөр багийн нутагт орших Аргал 1,627.02 гектар талбайн алтны үндсэн ордыг ил аргаар ашиглах (хүчин чадал 3.0 сая.тн/жил), исэлдсэн хүдрийг нуруулдан уусгах аргаар баяжуулах үйлдвэрийн төслийн Байгаль орчны менежментийн төлөвлөгөөг Байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээний тухай хууль (2012), Байгаль орчныг хамгаалах тухай хууль, түүнтэй нийцүүлэн гаргасан бусад хууль тогтоомж, Байгаль орчин, аялал жуулчлалын яамны сайдын 2019 оны 10 сарын 29-ний өдрийн А-618 тоот тушаалаар баталсан журмын дагуу уг төслийн Байгаль орчны нөлөөллийн нарийвчилсан үнэлгээ, Байгаль орчны менежментийн төлөвлөгөө, ордыг ашиглах техник эдийн засгийн үндэслэлд тулгуурлан боловсрууллаа.

Байгаль орчны менежментийн төлөвлөгөөний зорилго

Төсөл хэрэгжүүлэгч иргэн, хуулийн этгээдийн (цаашид төсөл хэрэгжүүлэгч гэх) байгаль орчныг хамгаалах талаар хуулиар хүлээсэн үүргээ биелүүлэх, тухайн жилийн байгаль орчны менежментийн төлөвлөгөөг боловсруулах, түүнийг хянан батлах, хэрэгжилтийг ханган тайлагнахтай холбогдсон харилцааг зохицуулахад энэхүү журмын зорилго оршино.

Тухайн жилийн байгаль орчны менежментийн төлөвлөгөөг төсөл хэрэгжүүлэгч боловсруулж, ерөнхий үнэлгээг хийсэн байгаль орчны асуудал хариуцсан төрийн захиргааны төв байгууллага, эсхүл аймаг, нийслэлийн байгаль орчны асуудал хариуцсан газарт хүргүүлэн хянуулж, батлуулна.

Ерөнхий үнэлгээ хийсэн байгууллагын хянаж, баталсан тухайн жилийн байгаль орчны менежментийн төлөвлөгөө нь төслийн үйл ажиллагааг эхлүүлэх, үргэлжлүүлэхийг зөвшөөрсөн байгаль орчны үндсэн баримт бичиг болно.

Тухайн жилийн байгаль орчны менежментийн төлөвлөгөө нь дараах хэсгүүдээс бүрдэнэ. Үүнд: Сөрөг нөлөөллийг бууруулах, арилгах арга хэмжээ (агаарын чанар, гадаргын ба газрын доорх усны нөөц, хөрсөн бүрхэвч, газрын хэвлий, ургамлын нөмрөг, амьтны аймгийг хамгаалах, хуримтлагдах нөлөөллийн үнэлгээгээр тогтоогдсон арга хэмжээ болон тухайн орон нутгийн нийгэм, эдийн засгийн хөгжлийг дэмжихэд чиглэсэн арга хэмжээг тусган), нөхөн сэргээх арга хэмжээ (техникийн болон биологийн нөхөн сэргээлт), биологийн олон янз байдлыг дүйцүүлэн хамгаалах арга хэмжээ, нүүлгэн шилжүүлэх, нөхөн олговор олгох арга хэмжээ, түүх, соёлын өвийг хамгаалах арга хэмжээ, химийн хортой болон аюултай бодисын эрсдэлийг бууруулах арга хэмжээ, хог, хаягдлын менежментийн арга хэмжээ, орон нутгийн захиргаа, аймаг нийслэлийн байгаль орчны газар, мэргэжлийн хяналтын байгууллага, ажлын хэсгийн дүгнэлт, шаардлагаар авч хэрэгжүүлэх арга хэмжээ, нөлөөллийн бүсийн оршин суугчдад тайлагнах үйл ажиллагаа, орчны хяналт шинжилгээний хөтөлбөр орно.

Энэ журмын 1.5-т заасан Орчны хяналт шинжилгээний хөтөлбөрт төслийн нөлөөлөлд өртөж буй байгаль орчны дор дурдсан бүрдэл хэсгүүдийг заавал тусгаж, бүрдэл хэсэг тус бүрээр хяналт шинжилгээ хийх цэгийн байршил, хэмжилт, дээжлэлт авах үзүүлэлт, тоо, хугацаа, давтамж, зарцуулах зардал, хариуцан гүйцэтгэх этгээд, баримтлах стандарт, аргачлалыг нарийвчлан тусгана. Үүнд: газрын гадарга, хэвлий, агаарын чанар, дуу шуугиан, гадаргын ба газрын доорх ус, хөрсөн бүрхэвч, ургамлын нөмрөг, амьтны аймаг, цацрагийн түвшин (цацраг идэвхт ашигт малтмал хайх, олборлох төсөлд), хортой болон хор хөнөөл учруулж болзошгүй бодис, материалыг хадгалалт, зарцуулалт, уурхайн хаягдлын далангийн аюулгүй байдал, нөхөн сэргээх арга хэмжээний үр дүн, тухайн уурхайн онцлогтой холбогдсон бусад барилга байгууламж орно.

Төсөл хэрэгжүүлэгч тухайн жилийн байгаль орчны төлөвлөгөөг ханган биелүүлж түүний үр дүнг тусгасан биелэлтийн тайланг 11 дүгээр сарын 01-ний дотор энэхүү журмын 3-р хавсралтын дагуу гаргаж, харьяалагдах аймаг, нийслэлийн байгаль орчны газарт 3-аас доошгүй хэвлэмэл хувь болон цахим хэлбэрээр хүргүүлнэ.

Байгаль орчныг хамгаалах төлөвлөгөөний хөтөлбөрийг хэрэгжүүлэхэд шаардлагатай зардлын задаргааг хэрэгжүүлэх он тус бүрээр доорх хүснэгтэд дэлгэрэнгүй харууллаа.

1.2.СӨРӨГ НӨЛӨӨЛЛИЙГ БУУРУУЛАХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨ

Төслийн үйл ажиллагаанаас байгаль орчны бүрдэл хэсгүүд, нутгийн иргэдийн амьдрах орчинд үзүүлэх сөрөг нөлөөллийг арилгах, бууруулах ажлыг төлөвлөхөөс гадна нөлөөллийн хамрах хүрээ, хэмжих нэгж, хариуцах хэлтэс, алба, хэрэгжүүлэх хугацаа, давтамж, баримтлах хууль эрх зүй, стандартууд, зарцуулах төсвийн задаргааг нэг бүрчлэн тусгасан болно.

Сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээний төлөвлөгөө 2026 он

Хүснэгт 5. Агаарын чанарын арга хэмжээ, зардал

№	Гол болон болзошгүй сөрөг нөлөөллүүд	Сөрөг нөлөөллийг арилгах, бууруулах арга хэмжээ	Хамрах хүрээ	Нэгжийн зардал /мян.төг/	Баримтлах эрх зүйн баримт бичиг
1	Тоосжилт болон бохирдуулагч хийн нөлөөгөөр орчны агаар бохирдох	Уурхайн карьер, овоолго, зам, талбайн усалгааны хэмжээ, норм, горимыг сар, улирлаар оновчтой тогтоох	Төслийн талбай	Агаарын бохирдлыг бууруулах үйл ажиллагааны зардал туссан.	MNS 4585:2007 Агаарын чанар. Техникийн ерөнхий шаардлага MNS 3383:1982 Агаар мандал. Бохирдлын эх үүсвэр, нөхцөл байдал ба тодорхойлолт MNS 4990:2000. Ажлын байрны эрүүл ахуй ба хөдөлмөр хамгаалал. Ажлын байрны орчин. Эрүүл ахуйн шаардлага MNS 5885:2008 Агаар бохирдуулагч бодисуудын хүлээн зөвшөөрөгдсөн концентрац. Техникийн ерөнхий шаардлага MNS (ISO) 4225:2001 Агаарын чанар. Ерөнхий танилцуулга
2		Ажлын байрны агаарын чанарыг сайжруулах, тоосжилтыг бууруулах арга хэмжээ тогтмол авч байх	Төслийн талбай	1,500.00	
3		Уурхайн болон үйлдвэрийн ухалт, ачилт буулгалтын цагийг хоногийн салхины горимтой уялдуулан зохион байгуулах	Төслийн талбай	Уулын ажлын төлөвлөгөөнд тусгагдсан	
4		Хүнд механизмын хөдөлгүүрийн тохиргоо, үйлчилгээг тогтмолжуулах, хөдөлгүүрээс гарах утааны хэмжээг стандартын шаардлага хангах хэмжээнд байлгах арга хэмжээ авах	Төслийн талбай	1,300.00	
5	Агаарын бохирдлын улмаас үйлдвэр дэх ажлын нөхцөл, ажилчид болон нутгийн иргэдийн эрүүл мэндэд нөлөөлөх	Уурхайн карьер доторх болон түүнээс гарч буй замуудад хайрга чулуу дэвсэх, замыг хусаж байх	Төслийн талбай	1,000.00	
6		Тоосноос эрүүл мэндээ хамгаалах нэг бүрийн хамгаалах хэрэгсэл, хүнсний нэмэлт бүтээгдэхүүнээр ажилчдыг хангах	Төслийн талбай	Хөдөлмөр хамгаалал, аюулгүй ажиллагааны зардал туссан	
7		Усалгаа хийхэд дан уснаас гадна нэмэлт бодис ашиглах боломжтой. Нэмэлт бодис ашигласнаар усны зарцуулалт буурч байгаа эсэх, тоос бууруулах үр ашиг, тухайн бодис нь байгаль орчинд ямар нэг нөлөөлөл, зардал мөнгө зэргийг харьцуулан судлан туршиж, амжилттай болсон туршлагыг нэвтрүүлэх.	Төслийн талбай	1,800.00	
8	Хүдэр бутлах шигших үед их хэмжээний тоосжилт үүсэх	Манан үүсгэгчээр нарийн ширхэгтэй усны ширхгүүдийг цацаж усан хөшиг үүсгэх өндрийн	Төслийн талбай	1,000.00	

		хэмжээ нь тоосны тархалтын өндөр, эрчмээс хамаарна.			
9	Үйлдвэрийн барилгын ажлын үед хөрс хуулах, тээвэрлэх болон үйлдвэрлэлийн үйл ажиллагаанд өртсөн ухмал, овоолгын талбайгаас ашиглалтын нийт хугацаанд тоосжилт үүсэх	Үйлдвэрийн барилгын ажил, хөрс хуулах-тээвэрлэх болон ашиглалтын үеийн ухмал, овоолгын талбайгаас үүсэх тоосжилтыг бууруулахын тулд тогтмол усалгааны горим мөрдөх, замын хурд хязгаарлах, тоос дарах бодис ашиглах, салхи хамгаалах байгууламж байгуулах, материалын овоолгыг боож хамгаалах зэрэг иж бүрэн арга хэмжээг хэрэгжүүлэх	Төслийн талбай	1,000.00	
10	Химийн бодисын агуулахад химийн бодистой харьцан ажиллах үед санамсаргүй асгах, алдах, агуулахын шал, гадаад орчинд асгарсанаас ажлын байрны орчны агаарт нөлөөлөх	Химийн бодисын агуулахын ажиллагсад бодистой ажиллах болон асгарсан бодисыг саармагжуулах, хурааж авах зэрэг ажиллагааны явцад хөдөлмөр хамгааллын хувцас хэрэгсэлгүй ажиллах зэрэг тохиолдолд бодист түлэгдэх, бодисын уураар амьсгалах, хордох зэрэг эрсдэл үүсч болзошгүй тул хөдөлмөр хамгаалал аюулгүй ажиллагааг сайтар ханган ажиллах	Боловсруулах үйлдвэр	Хөдөлмөр хамгаалал, аюулгүй ажиллагааны зардалд туссан	MNS 6458:2014, Хөдөлмөрийн аюулгүй ажиллагаа, эрүүл ахуй. Химийн хорт болон аюултай бодис, бүтээгдэхүүний агуулах. Ерөнхий шаардлага, Химийн бодис тус бүрийн хор аюулын лавлах мэдээлэл /MSDS/-ийг ашиглах
11	Химийн хорт болон аюултай бодис агуулж байгаа сав нь хэт удаан хадгалах, нарны гэрэл тусах, хөлдөх, халах, зэврэх, урвалд орох зэргээс эвдрэх, цоорох, зөөлрөх зэрэг гэмтлээс шалтгаалан асгарч алдагдах, ажлын байрны агаарт тархах	Химийн хортой болон аюултай бодисын хадгалалтын болон хадгалах хугацааны горимыг нарийн чанд баримтлах, ялангуяа тодорхой хугацааны дараа уурших, задрах гэх мэтээр бүтэц найрлага нь өөрчлөгддөг тогтвортой биш бодис болон савлагааны материал нь хязгаарлагдмал ашиглалтын хугацаатай химийн бодисыг агуулахад хадгалахад үйлдвэрлэгчээс зааж өгсөн хугацааг хянаж, хуучин бодисыг эхэлж ашиглах зарчмыг баримтлах	Боловсруулах үйлдвэр	Үйл ажиллагааны зардалд тусгах	MNS 6458:2014, Хөдөлмөрийн аюулгүй ажиллагаа, эрүүл ахуй. Химийн хорт болон аюултай бодис, бүтээгдэхүүний агуулах. Ерөнхий шаардлага, Химийн бодис тус бүрийн хор аюулын лавлах мэдээлэл /MSDS/-ийг ашиглах
12	Химийн хортой болон аюултай бодисыг гадна талбайд ил задгай хаяснаас агаарт тэсрэмтгий хольц үүсгэх, гадаад орчинд агаарын урсгалаар дамжин нөлөөлөх	Химийн бодисыг шатах, гал авалцах эх үүсвэр болон хамт хадгалж болохгүй бодисуудыг тусад нь хадгалах	Боловсруулах үйлдвэр	Үйл ажиллагааны зардалд тусгах	
13	Химийн бодисын тээвэрлэлт, хадгалалтын горим алдагдсанаас ууршимтгай, дэгдэмхий бодисууд агаарт уурших, исэлдэн урвалдах зэргээр агаарын чанар найрлагад нөлөөлөх	Химийн бодисын агуулахын хадгалах нөхцөлийг стандартын шаардлагын түвшинд тохижуулах, хор аюулын лавлах мэдээлэлд тусгагдсан зааврын дагуу хадгалах, ялангуяа химийн бодисын агуулахад хор аюулын лавлах мэдээлэлд	Боловсруулах үйлдвэр	700.00	MNS 6458:2014, Хөдөлмөрийн аюулгүй ажиллагаа, эрүүл ахуй. Химийн хорт болон аюултай бодис, бүтээгдэхүүний агуулах. Ерөнхий шаардлага Химийн бодис тус бүрийн хор

14	Химийн бодистой шатах, гал авалцах эх үүсвэрийг ойр байлгаснаар гал түймэр гарах, тэсэрч дэлбэрснээр хортой хий ялгаран агаарын чанар, хүний эрүүл мэндэд нөлөөлөх	тусгагдсаны дагуу хоорондоо нийцэхгүй бодисуудыг хамт хадгалахгүй байх	Боловсруулах үйлдвэр		аюулын лавлах мэдээлэл /MSDS/-ийг ашиглах
15	Химийн бодисыг хадгалах үед хор аюулын лавлах мэдээлэлд заасан хадгалах нөхцөлийг хангасан орчныг агуулахад бүрдүүлээгүйгээс агаарын найрлага өөрчлөгдөх, улмаар хүний эрүүл мэндэд нөлөөлөх	Химийн бодисын агуулахад шатах, гал авалцах эх үүсвэр болон шатамхай, тэсэрч дэлбэрэх эрсдэлтэй бодис, бүтээгдэхүүнийг нэг дотор хадгалахгүй байх	Боловсруулах үйлдвэр	2,300.00	
Нийт дүн					10,600.00

Хүснэгт 6. Газрын гадарга, хэвлийд авах арга хэмжээ, зардал

№	Гол болон болзошгүй сөрөг нөлөөллүүд	Сөрөг нөлөөллийг арилгах, бууруулах арга хэмжээ	Хамрах хүрээ	Нэгжийн зардал /мян.төг/	Баримтлах эрх зүйн баримт бичиг
1	"Ордын болон Исэлдсэн хүдэр боловсруулах үйлдвэрийн хугацаанд уурхайлалтад нийт 109.31 га талбай, исэлдсэн хүдэр барьж байгуулах ашиглах хүрээнд 70.46 га 312.54 мян.м3 үржил шимт хөрс үйл ажиллагааны нөлөөлөлд өртөх"	Олборлолтын үйл ажиллагаанаас газрын гадарга, хэвлийд үзүүлэх сөрөг нөлөөллийг арилгах юм уу бууруулах арга байхгүй ч олборлолтын үйл ажиллагаа болон барилгын ажил дууссаны дараа нөхөн сэргээлт хийх, ургамалжуулах, тохижуулах ажлыг төлөвлөгөөний дагуу гүйцэтгэснээр сөрөг нөлөөллийг бууруулах боломжтой.	Уурхайн карьер, ухаш	Техникийн сэргээлтийн тусгагдсан нөхөн зардалд	Газрын хэвлийн тухай хууль, Хөрс хамгаалах тухай хууль, MNS 3473:1993. Газар ашиглалт. Нэр томъёо, тодорхойлолт MNS 5914-2008. Байгаль орчин. Эвдэрсэн газрын нөхөн сэргээлт. Нэр томъёо, тодорхойлолт
2	Уурхайн карьер, ухаш		Техникийн сэргээлтийн тусгагдсан нөхөн зардалд		
3	"Үржил шимт хөрсний овоолго, хөрсний гадаад овоолго, хүдрийн овоолгод ашиглалтын 6 жилийн хугацаанд газрын гадаргад 5 м өндөртэй, 102.2 га талбайг эзэлсэн овоолго бий болж гадаргын төрхийг өөрчлөх"		Үржил шимт хөрсний овоолго, хөрсний гадаад овоолго, хүдрийн овоолго	Техникийн сэргээлтийн тусгагдсан нөхөн зардалд	
4	Хүдрийг нуруулдах үед агаарт тоосжилт үүсэх, улмаар цаг уурын нөхцөл байдлаас шалтгаалан 50-250 м зайд тархах, орчныг бохирдуулах	Тайлангийн 6 дүгээр бүлгийн 6.3. дэх хэсэгт заасан агаарын чанарт үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээ, тоосжилтыг бууруулах, орчинд нь тарахаас урьдчилан сэргийлэх, бууруулах, арилгах зорилгоор хийгдэх боломжтой	Лицензийн талбай	1,000.00	

		арга хэмжээнүүдийг зөвлөмжийг хэрэгжүүлэн ажиллах			
5	Уурхайн болон үйлдвэрийн технологийн үйл ажиллагаа нь байгаль орчны бүрэлдэхүүн хэсэг, ялангуяа үйлдвэрийг барьж байгуулах үед газрын гадарга, хөрс, түүний геологийн тогтоц, хэвлийд өөрчлөлт гарах	Ашиглалтын явцад үүссэн хаягдал чулуулаг, овоолгыг үе шаттайгаар нөхөн сэргээх, техникийн нөхөн сэргээлт, хэлбэржүүлэлт дээр онцгой анхаарал тавьж ажиллах	Газрын хэвлий	Техникийн сэргээлтийн тусгагдсан	нөхөн зардалд
6	"Олборлолтын талбайгаас эргэн тойрон 100 метр зайд хөрс, ургамал халцрах болон талхлагдах, зам харгуй гарах зэргээр сөрөг нөлөөлөл бий болох"	"Уурхайн эдэлбэр газар болон бутлуулын талбай эдэлбэр талбай нь хүчтэй нөлөөллийн бүсээс эргэн тойрон 100 метрт хөрс, ургамал халцрах болон талхлагдах, зам харгуй гарах дунд зэргийн сөрөг нөлөөлөл бий болох боловч энэ нь байгалийн жамаар нөхөн сэргээгдэх боломжтой. Улмаар дунд зэргийн нөлөөллийн хүрэнээс гадагш 200 метр дотор бага зэргийн нөлөөлөл үүсэх боломжтой боловч заримдаа нөлөөлөлгүй ч байх талтай тул энд нөхөн сэргээлтийн асуудал тавигдахгүй.	Нөлөөллийн бүс	Техникийн сэргээлтийн тусгагдсан	нөхөн зардалд
7	Бутлуурын талбайгаас эргэн тойрон 100 метр зайд хөрс, ургамал халцрах болон талхлагдах, зам харгуй гарах зэргээр сөрөг нөлөөлөл бий болох				
8	"Нөлөөллийн хүрэнээс гадагш 200 метр дотор хүний үйл ажиллагаа, машин техникийн нөлөөлөл үүсэх"				
9	"Ордын ашиглалтын талбайд болон үйлдвэрлэлийн орчмын ургамал талхлагдах, хөрс хуулалтын улмаас уурхайн талбайн ургамлан нөмрөг бүрэн устахын зэрэгцээ орчных нь талбайн ургамал, шимт хөрсний гадаад овоолгод түр хугацаанд дарагдах"	Уурхай болон үйлдвэр түүнтэй холбоотой дэд бүтцийг хөгжүүлэх явцад үүсэх талбайн газрын эвдрэл болон орчны өөрчлөлтийг багасгах, урт хугацааны тогтвортой байдлыг хангах зорилгоор гадаргын хоосон орон зайг зөв зохистой хэлбэржүүлэн эцэслэн шийдэх шаардлагатай. Үүний зэрэгцээ төслийг хэрэгжүүлэх орчны анхны төрх, хэлбэрийг хадгалж, тухайн газрын тогтвортой, аюулгүй байдлыг хамгаалах, уурхайн хаалт болон нөхөн сэргээлтийн зорилтуудыг бүрэн хэрэгжүүлэх	Үржил шимт хөрсний овоолго, хөрсний гадаад овоолго, хүдрийн овоолго	Техникийн сэргээлтийн тусгагдсан	нөхөн зардалд
10	"Олборлолт, овоолго болон тээвэрлэлт хийж буй техникийн хөдөлгөөний улмаас хөрс элэгдэл эвдрэлд орох"		Овоолго, дотоод зам, тээврийн зам	Техникийн сэргээлтийн тусгагдсан	нөхөн зардалд
11	"Ашиглалтын жилүүдэд бэлчээрийн эдэлбэр газар багасаж, газрын өнгө төрх өөрчлөгдөх"		Лицензийн талбай	Техникийн сэргээлтийн тусгагдсан	нөхөн зардалд
Нийт дүн				1,000.00	

Хүснэгт 7. Амьтны аймгийн арга хэмжээ, зардал

№	Гол болон болзошгүй сөрөг нөлөөллүүд	Сөрөг нөлөөллийг арилгах, бууруулах арга хэмжээ	Хамрах хүрээ	Нэгжийн зардал /мян.төг/	Баримтлах эрх зүйн баримт бичиг
1	Илүү уурхайн болон Исэлдсэн хүдэр боловсруулах үйлдвэр, түүнийг дагасан үндсэн болон туслах барилга байгууламж, дэд бүтцийн бүтээн байгуулалт, газар шорооны ажлын үед мэргэч болон мөлхөгч амьтдын амьдрах орчин устаж үгүй болох, тоо толгой цөөрөх	Байгаль орчныг хамгаалах төлөвлөгөөг чанд хэрэгжүүлэх болон эвдэрсэн хөрсийг нөхөн сэргээж сайжруулах замаар төслийн зүгээс амьтны аймагт учруулах сөрөг нөлөөллийг, хамгийн бага түвшинд байлгах буюу хязгаарлах шаардлагатай.	Биологийн олон янз байдал	Урьдчилан тооцох боломжгүй	Байгаль орчныг хамгаалах тухай хууль; Байгаль орчны нөлөөллийн үнэлгээний тухай хууль; Ховор, устаж болзошгүй амьтан, ургамлын тухай хууль; Ашигт малтмалын тухай хуулийн нөхөн сэргээлтийн шаардлага болон холбогдох MNS стандартууд
2	Үйлдвэрийн үйл ажиллагааны үед тухайн орчны сээр нуруугүйтэн амьтдын амьдрах орчныг хязгаарлаж, тоо толгойг цөөрүүлэх		Биологийн олон янз байдал	Урьдчилан тооцох боломжгүй	
3	Үйлдвэр, уурхайн тээвэрлэлтийн үед ашиглах хүнд даацын машин механизм, автомашинуудын хөдөлгөөнөөс үүсэх дуу чимээ, гэрэл, хорт утаа, газар шорооны ажилтай холбоотойгоор үүсэн бий болох тоосжилт зэргээс үүдэн тухайн ажил явагдаж байгаа газрын ойр орчимд нутагладаг ан амьтад үргэн дайжих, амьдрах орчноо алдах	Ан амьтны үхэж хорогдохоос сэргийлэхийн тулд үйлдвэрийн байгууламж руу ан амьтан орохоос хамгаалах арга хэмжээ авах, үйлдвэрийн ашиглагдсан талбайг нөхөн сэргээх болон бусад аливаа үйл ажиллагааны үед ан амьтны байршил нутагт нөлөөлөхгүй байхад илүүтэй анхаарах	Биологийн олон янз байдал	Урьдчилан тооцох боломжгүй	
4	Аливаа нэгэн зүйл устаж, дайжиж алга болсонтой холбоотойгоор экологийн идэш тэжээлийн харилцаа холбоо алдагдах		Биологийн олон янз байдал	Урьдчилан тооцох боломжгүй	
5	Тухайн нутагт нутагладаг зэрлэг амьтад болон мал үйлдвэрийн ухаш, шуудуунд унаж бэртэх, хорогдох	Тухайн нутагт нутагладаг зэрлэг амьтад болон мал үйлдвэрийн талбайд орох ухаш, шуудуунд унаж бэртэх, хорогдохоос урьдчилан сэргийлэх, нуруулдан уусгалтын талбайд шувуу үргээгч байрлуулах	Биологийн олон янз байдал	1,500.00	
6	Агнуурын ач холбогдолтой, ховордож буй болон улаан номд орсон төрөл зүйлийг үйлдвэрийн ажилчид хулгайгаар агнах	Ажиллагсад орон нутагт ан хийхийг хориглох, галт зэвсэг болон бусад зэвсэг хэрэгсэл байлгахыг хориглох	Биологийн олон янз байдал	Урьдчилан тооцох боломжгүй	
7	Уурхайн үйл ажиллагааны улмаас зэрлэг амьтдын амьдрах орчны усны хүртээмж буурах	Уламжлалт усан сангаар хангах боломж хязгаарлагдмал нөхцөлд нарны өргүүртэй худаг байгуулж, усны түвшинг тогтвортой байлгах инженерийн шийдэл бүхий хамгаалалтын байгууламж, ус уух тавцан, амьтад аюулгүй нэвтрэх орчныг	Биологийн олон янз байдал	Дүйцүүлэн хамгаалах арга хэмжээний төлөвлөгөөнд тусгагдсан	

	бүрдүүлэн, уурхайн бүсийн гадна болон нөлөөллийн бүсийн гол зөрөг маршруттай уялдуулан байршуулж, тогтмол арчилгаа-хяналтын дэглэмийг мөрдүүлэх			
Нийт дүн				1,500.00

Хүснэгт 8. Ургамлан нөмрөгийн арга хэмжээ, зардал

№	Гол болон болзошгүй сөрөг нөлөөллүүд	Сөрөг нөлөөллийг арилгах, бууруулах арга хэмжээ	Хамрах хүрээ	Нэгжийн зардал /мян.төг/	Баримтлах эрх зүйн баримт бичиг
1	Ил уурхайн болон үйлдвэрийн барилга байгууламжуудыг барьж байгуулахад 7 жилийн хугацаанд нийт 259.12 га талбай, 312.54 мян.м3 үржил шимт хөрс үйл ажиллагааны нөлөөлөлд өртөх, бүрэн устгах	Зөвлөмжид заасны дагуу талхлагдалд өртөхөөс өмнө хамгаалах арга хэмжээ авах ба ургамалжилт болон хөрсний хэв шижийг нарийвчлан судалж тухайн газар нутгийн хөрс, ургамлан нөмрөгт тохирсон нөхөн сэргээлтийн ажлыг хийх шаардлагатай. Биологийн нөхөн сэргээлтийг тайлангийн 6 дугаар бүлгээс үзнэ үү.	Биологийн олон янз байдал	Нөхөн сэргээлтийн зардалд туссан.	MNS 5918:2008 Байгаль орчин. Эвдэгдсэн газрын ургамлыг нөхөн сэргээх. Техникийн ерөнхий шаардлага
2	Ургамлан бүрхэвчийг устгаснаас үүдэх дам сөрөг нөлөөллүүд нь хөрс эвдрэлд өртөмхий болох, хөрсний сул шороо агаарт дэгдэж агаарын тоосжилтыг нэмэгдүүлэх, улмаар энэ нь эргээд ургамал болон байгаль орчинд шууд болон дам хэлбэрээр нөлөөлөх	Замын хажуугаарх ургамлыг тоосжилтод өртөхөөс хамгаалж, замын арчилгааг хийснээр ургамалжилтад учруулах сөрөг нөлөөллийг хамгийн доод хэмжээнд байлгах, хучилтгүй зам дээр явах машины хурдыг хязгаарлах	Биологийн олон янз байдал	Урьдчилан тооцох боломжгүй	
3	Ургамлан нөмрөгийн фотосинтезийн идэвх буурах, өсөлт удаашрах улмаар өсөлт нь бүрмөсөн зогсож ургахаа болих	Үйлдвэрийн ашиглалтын үед замын маршрут тогтоон замбараагүй олон салаа зам гарах, ургамлан нөмрөг талхлагдахаас урьдчилан сэргийлэх, тэмдэгжүүлэх	Биологийн олон янз байдал	1,000.00	
4	Үйлдвэрийн ашиглалтын үед замын маршрут тогтоогоогүйгээс замбараагүй олон салаа зам гарах, ургамлан нөмрөг талхлагдах		Биологийн олон янз байдал		
5	Бутлуурын үйлдвэрлэлийн талбайн нөлөөллийн бүсийн эргэн тойрон 100 метр зайд хөрс, ургамал халцрах болон талхлагдах, зам харгуй гарах зэргээр сөрөг нөлөөлөл бий болох	Үйлдвэрийн эдэлбэр талбай болох хүчтэй нөлөөллийн бүсээс эргэн тойрон 100 метрт хөрс, ургамал халцрах болон талхлагдах, зам харгуй гарах дунд зэргийн сөрөг нөлөөлөл бий болох боловч энэ нь байгалийн жамаар нөхөн сэргээгдэх боломжтой. Улмаар дунд зэргийн нөлөөллийн хүрээнээс гадагш 200 метр дотор бага зэргийн нөлөөлөл үүсэх боломжтой боловч заримдаа	Биологийн олон янз байдал	Нөхөн сэргээлтийн зардалд туссан.	

		нөлөөлөлгүй ч байх талтай тул энд нөхөн сэргээлтийн асуудал тавигдахгүй.			Байгаль орчны нөлөөллийн үнэлгээний тухай хууль; Байгалийн нөөц ашигласны төлбөрийн тухай хууль болон холбогдох MNS стандартуудын шаардлага
6	Нөлөөллийн хүрэнээс гадагш 200 метр дотор хүний үйл ажиллагаа, машин техникийн нөлөөлөл үүсэх	Машин техникийн хөдөлгөөнийг батлагдсан маршрутаар зохион байгуулж, түр зам болон эргэлтийн цэгийг хамгаалалтын бүсээс дотогш төлөвлөн, хөдөлгөөний хурдны хязгаарыг тогтоож мөрдүүлнэ.	Биологийн олон янз байдал	Нөхөн сэргээлтийн зардалд туссан.	
Нийт дүн					1,000.00

Хүснэгт 9. Хөрсөн бүрхэвчний арга хэмжээ, зардал

№	Гол болон болзошгүй сөрөг нөлөөллүүд	Сөрөг нөлөөллийг арилгах, бууруулах арга хэмжээ	Хамрах хүрээ	Нэгжийн зардал /мян.төг/	Баримтлах эрх зүйн баримт бичиг
1	Исэлдсэн болон анхдагч хүдэр боловсруулах үйлдвэрийн ашиглалтын 7 жилийн хугацаанд нийт 259.12 га талбай, 312.54 мян.м3 үржил шимт хөрс үйл ажиллагааны нөлөөлөлд өртөх, бүрэн устгах	Уурхайн ашиглалт, барилга угсралт, дэд бүтцийн ажлын үед зөвшөөрөлгүй газар хөндөхөөс урьдчилан сэргийлэх зорилгоор "Газар хөндөх зөвшөөрөл олгох, үржил шимт хөрсийг хуулж хадгалах" журмыг боловсруулж батлан хэрэгжүүлэх	Газрын хэвлий	Урьдчилан тооцох боломжгүй	MNS 5914-2008. Байгаль орчин. Эвдэрсэн газрын нөхөн сэргээлт. Нэр томъёо, тодорхойлолт
2		Инженер, геодези, ХЭМАБ, Байгаль орчны баг ажилбар бүрийн өмнө талбайг хамтран шалгаж, зөвшөөрөгдсөн хилд байгаа эсэхийг нотлон акт үйлдэх.	Газрын хэвлий	Урьдчилан тооцох боломжгүй	MNS 3298:1991 Хөрс. Хөрсний дээж авах ерөнхий шаардлага
3		Барилгын хог хаягдал, том чулууг хөрс бохирдуулахгүйгээр тусад нь хадгалж, мэргэжлийн байгууллагаас тогтоосон цэгт зайлуулж байх	Хог хаягдал	1,200.00	"Тусгай зориулалтын авто зам, замын байгууламж барих, ашиглах журам"
4	Үржил шимт хөрсний овоолго, хөрсний гадаад овоолго, чанарын бус хүдрийн овоолгод ашиглалтын 7 жилийн хугацаанд газрын гадаргад 5 м өндөртэй, 102.2 га талбайг эзэлсэн овоолго бий болж хөрсөн бүрхэвчийг дарах	Ил уурхай, овоолго байгуулах талбайн үржил шимт хөрсийг хуулж, 5 мээс өндөргүй овоолон хадгалах	Шимт хөрс	Нөхөн сэргээлтийн зардалд туссан.	батлах тухай Засгийн газрын 2018 оны 379 тоот тогтоол
5		Хуримтлуулсан шимт хөрсний овоолгыг салхи хаагч бүс, ургамалжуулалтын түр бүрхүүлээр хамгаалах.	Шимт хөрс	Нөхөн сэргээлтийн зардалд туссан.	"Тусгай зориулалтын авто зам, замын

6		Шимт хөрсийг элэгдэлд өртөх талбайд гадаргын хажуугийн тогтворжилт хийх (налуу тохижуулалт, шатлан буулгалт), урьдчилан сэргийлэх хамгаалалтын шуудуу, барьер байгуулах.	Шимт хөрс	Нөхөн сэргээлтийн зардалд туссан.	байгууламж барих, ашиглах журам" батлах тухай Засгийн газрын 2018 оны 12 дугаар сарын 12 ны өдрийн 379 тоот тогтоол
7	Тээвэрлэлтийн улмаас хөрсний эвдрэл үүсэх	Тогтсон маршрутын дагуу тээвэрлэлт хийх замын тэмдэглэгээ байршуулах	Хөрсөн бүрхэвч	Урьдчилан тооцох боломжгүй	
8		Замыг тэмдэгжүүлж, салаа зам гаргахаас сэргийлсэн ухуулах самбар хийж байрлуулах	Хөрсөн бүрхэвч	800.00	
9		Олон салаа зам гарахаас сэргийлж тэмдэг, тэмдэглэгээ байрлуулах	Хөрсөн бүрхэвч		
10	Ахуйн хаягдал, шатах, тослох материал алдагдах, баяжуулах үйлдвэрлэлийн үйл ажиллагааны явцад хөрс бохирдох	Шатах, тослох материал, ажилласан тосны хаягдлыг зориулалтын саванд хадгалах, орчинд асгарч алдагдахаас сэргийлэх	Хөрсөн бүрхэвч	1,000.00	
11		ШТС, агуулах болон засварын төвийн талбайг хатуу хучилттай болгож газрын гадарга, хөрс бохирдохоос сэргийлэх	Хөрсөн бүрхэвч	1,000.00	
12		Химийн бодисын агуулахад болон аюултай хог хаягдал хадгалах цэг, техник, тоног төхөөрөмжийн засварын талбай, генераторуудын орчид асгаралтын багц байршуулах	Хөрсөн бүрхэвч	1,000.00	
13		Ахуйн бохир усыг ил задгай асгах, бохир усны цооног халих, бохир усыг доторлогоогүй цооногт хадгалах зэргээр хөрс бохирдуулахаас сэргийлэх	Хөрсөн бүрхэвч	1,350.00	
14		Техникийн бүрэн бүтэн байдлыг тогтмол шалган тос/түлшний алдагдлыг эрт илрүүлэх арга хэмжээг хэрэгжүүлэх.	Хөрсөн бүрхэвч	Урьдчилан тооцох боломжгүй	
15		Асгаралт гарах магадлалтай хэсгүүдэд шингээгч материал, хурдавчилсан хариу арга хэмжээний иж бүрдэл бэлэн байлгах.	Хөрсөн бүрхэвч	1,000.00	

16		Ажилчдын байранд нэгдсэн ариун цэврийн өрөө төлөвлөж барих шаардлагатай байгаа бөгөөд бохир ус нийлүүлэх цооног, орчны талбайг бетондох, хашлага хийж, бохир ус гадагш урсахааргүй болгож тохижуулах	Хөрсөн бүрхэвч	1,000.00	
17	Хүдэр бутлах шигших үед үүссэн тоосонцрын нөлөөгөөр хөрсний гадаргад үүсэх болзошгүй хүнд металлын бохирдол	Бутлуур, шигшүүр, конвейерийн бүх зангилаанд тоос баригч систем (bag filter, scrubber, cyclone) суурилуулж найдвартай ажиллагааг хангах.	Бутлуурын үйлдвэр	Үйл ажиллагааны зардалд тусгах	
18		Бутлах шигших талбайд сар бүр хүнд металлын шинжилгээ (As, Pb, Cd, Cu, Zn, Ni гэх мэт) хийж “суурь түвшин”-гэй харьцуулах.	Бутлуурын үйлдвэр	Орчны хяналт шинжилгээний хөтөлбөрт тусгагдсан	
19		Хүнд металлын агууламж нэмэгдсэн бүсийг эрт илрүүлэх мониторингийн цэгийг бутлах, шигших талбайгаас (0–50 м, 50–100 м, 100–200 м) тогтоож сар бүр шинжилгээ авч харьцуулах	Бутлуурын үйлдвэр	Орчны хяналт шинжилгээний хөтөлбөрт тусгагдсан	
20		“Хүдэр бутлах-шигших дамжлагын тоосжилт ба хүнд металлын бохирдлоос урьдчилан сэргийлэх журам”-ыг боловсруулж батлах.	Бутлуурын үйлдвэр	Урьдчилан тооцох боломжгүй	
21		Бутлах, шигших талбайд үүссэн нарийн ширхэглэлтэй хүдрийн үлдэгдлийг тогтмол хусаж цуглуулан зориулалтын овоолго үүсгэн, зонхилох салхинаас нөмөр бүсэд ачиж байршуулж, тухайн талбайг тусгаарлан анхааруулах тэмдэглэгээ хийж, тээврийн хэрэгслийн хөдөлгөөнөөс хамгаалах зохион байгуулалтын арга хэмжээг хэрэгжүүлэх.	Бутлуурын үйлдвэр	1,000.00	

22	Химийн бодисын агуулахын барилгын хийц, инженерийн байгууламжийн төлөвлөлт, гүйцэтгэлийн доголдол, химийн бодисын тээвэрлэлт, хадгалалт, ашиглалтыг горим алдагдсанаар хөрсөнд их хэмжээгээр шингэх, хөрсөн бүрхэвчинд сөрөг нөлөөлөх	Химийн бодисын агуулахын барилга байгууламж нь шалыг химийн үйлчлэлд гэсвэртэй зузаан материалаар хийх боловч нэвчилт, алдагдлыг байнга шалгаж, шаардлагатай арга хэмжээг тухай бүр авч байх	Боловсруулах үйлдвэр	Урьдчилан тооцох боломжгүй	
23	Химийн бодис тээвэрлэх, хадгалах, ашиглалтын үйл ажиллагааг шаардлагын дагуу зөв явуулаагүйгээс химийн бодисыг хөрсөнд алдаж, түүний найрлага бүтцийг өөрчлөх	Тээвэрлэлт, хадгалалтын үйл ажиллагааг шаардлагын дагуу зөв явуулах, химийн бодисыг хөрсөнд алдахаас урьдчилан сэргийлэх арга хэмжээг байнга авч хэрэгжүүлэх	Боловсруулах үйлдвэр	Урьдчилан тооцох боломжгүй	
24	Хөрсөнд их хэмжээний химийн бодис алдагдсанаар ургамалжилт, хөрсний бичил биетэнд дам нөлөөлөл үзүүлэх	Химийн бодисын агуулахын ажлын байр нь тухайн бодисын хор аюулын лавлах мэдээлэлд заасан шингээгч материалаар (зориулалтын шингээгч, хуурай элс, тогтворжуулагч, үртэс гэх мэт) хангагдсан байна. Химийн бодис асгарах, алдагдах үед ашиглах нэг бүрийн хамгаалах хэрэгсэл, хоосон сав, бортого, бортого онгойлгогч, наалддаг шошго, металл юүлүүр, хүрз, хогийн шүүр, хориглох тэмдэг болон тууз зэрэг багаж хэрэгслээр хангагдсан байх	Боловсруулах үйлдвэр	500.00	
Нийт дүн				9,850.00	

Хүснэгт 10. Гадаргын болон газрын доорх усны арга хэмжээ

№	Гол болон болзошгүй сөрөг нөлөөллүүд	Сөрөг нөлөөллийг арилгах, бууруулах арга хэмжээ	Хамрах хүрээ	Нэгжийн зардал /мян.төг/	Баримтлах эрх зүйн баримт бичиг
1	Төслийн ус хангамжийн цооног байрлах газрын доорх усны нөөц хомсдох	Үйлдвэрлэлийн үйл ажиллагаанд ус ашиглахдаа үйлдвэрлэлийн зориулалтаар ашиглах усны батлагдсан нөөц болон усны боломжит нөөцөөс хэтрүүлэн ашиглахгүй байх	Боловсруулах үйлдвэр	Урьдчилан тооцох боломжгүй	Усны тухай хууль /шинэчилсэн найруулга/, "Ус ашиглалт, хэрэглээг тоолууржуулах" журам батлах тухай БОНХС-ын

2		Дэд бүтцийн бүх усны шугамд тоолуур суурилуулж алдагдлыг хянах	Дэд бүтэц	Урьдчилан боломжгүй	тооцох	2013 оны А-156 тоот тушаал "Ус ашиглагч иргэн, аж ахуйн нэгж, байгууллага нь ахуйн бохир ус зайлуулах цэгээ ус тусгаарлагчаар тусгаарлаж тохижуулах" журам батлах тухай БОАЖС, ЭМС-ын 2018 оны А-82, А-128 тоот хамтарсан тушаал
3		Ажилчдын орон сууц, угаалга, гал тогооны нэгжүүдэд байрлах бүх цоргонуудад усны зарцуулалтыг 30-50 хувь хүргэл бууруулах боломжтой ус хэмнэгч хошуу (aerator, low-flow faucet) суурилуулж, хэрэглээг нормчилсон горимоор удирдах, тогтмол шалгалт хийж элэгдэл, гоожилтыг бууруулах хяналтын дэглэмийг хэрэгжүүлэх.	Усан хангамж	Урьдчилан боломжгүй	тооцох	
4	Төслийн талбайн газрын доорх усыг их хэмжээгээр татан авах нөхцөлд газрын доорх усны түвшин, урсцын чиглэлд өөрчлөлт гарах	Үйлдвэрлэлийн усан хангамжийг газрын доорх уснаас шууд хангахаас зайлсхийж, Туул голын усны нөөц, урсацын горимын нарийвчилсан судалгаа хийсний үндсэн дээр эргийн шүүрүүлэх (infiltration gallery) болон ус хуримтлуулах инженерийн байгууламж барьж гадаргын усыг зохистой хэмжээнд ашиглан үйлдвэрлэлийн усны хэрэглээг хангах шийдлийг хэрэгжүүлэх	Усан хангамж	5,000.00		
5		Туул голын голын урсац, түвшин, усны чанар, бороо ба цасны хайлалтын үеийн хэлбэлзлийг бодит цагийн мэдээллийн санд бүртгэдэг автомат хяналтын станц (flow meter, level sensor, water quality sensor)-уудыг суурилуулж, өгөгдлийг цахим платформоор удирдан дүн шинжилгээ хийх, улирал бүрийн өөрчлөлттэй уялдуулан усны нөөцийн судалгаа хийх	Гадаргын ус	Үйл ажиллагааны зардалд тусгах		
6	Химийн бодисын хэрэглээ, шатах тослох материалыг газрын гадарга, хөрсөн бүрхэвчид алдсанаар хөрсөн бүрхэвч, ургамал нөмрөг бохирдож, улмаар агаарын хур тунадасны угаагдлаар бага гүний ус бохирдох	Химийн бодис, шатах тослох материалын хадгалалт, ашиглалтын үеийн хөдөлмөр хамгаалал, аюулгүй ажиллагааг чанд мөрдөн ажиллах, бохирдол үүсэхээс урьдчилан сэргийлэх	Боловсруулах үйлдвэр	Урьдчилан боломжгүй	тооцох	
7	Унд-ахуйн усны эх үүсвэр болох гүний худагт ариун цэврийн болон хамгаалалтын бүс тогтоогоогүйгээс бохирдох	Гүний худгийн эргэн тойронд эрүүл ахуйн болон ариун цэврийн хамгаалалтын бүс тогтоож хашаажуулах	Газар доорх ус	3,500.00		
8	Үер усны аюул, байгалийн гамшгаас шалтгаалан хаягдлын сан, нуруулдан уусгалтын талбайн үерийн усны далан сэрэх,	Тайланд тусгагдсан их урсцын тооцоонд үндэслэн сайрын судалгааг Гамшгийн эрсдэлийн үнэлгээний түвшинд нарийн судалж нэмэлтээр хийх. Гарсан үр дүнд тулгуурлан сайрын голдиролд орж ирэх усыг	Лицензийн талбай	Урьдчилан боломжгүй	тооцох	

	ханийн бэхэлгээ нурснаас бохир ус алдагдаж гадаргын болон гүний усыг бохирдуулах	аюулгүйгээр зайлуулан урсгах инженерийн барилга байгууламжийг мэргэжлийн эрх бүхий байгууллагаар гүйцэтгүүлэх. Уг үерээс хамгаалах зорилгоор барьсан байгууламж нь болзошгүй эрсдэл, нөлөөллөөс бүрэн хамгаалж чадах эсэхэд судалгаа хийлгэж, зохих арга хэмжээг авах		
9	Тээвэрлэх, хүлээн авах үйл ажиллагааг шаардлагын дагуу зөв явуулаагүйгээс химийн бодисыг түр урсцын голдирлуудад асгах, талбайд татан ирэх явцад бохирдлын эх үүсвэрийг бий болгох	Химийн бодисын агуулахад химийн бодис, бүтээгдэхүүнийг татан авчрах, хүлээн авах үйл ажиллагааг явуулахдаа хөдөлмөр хамгаалал аюулгүй ажиллагааг хангах ажиллах	Боловсруулах үйлдвэр	Урьдчилан тооцох боломжгүй Үйл ажиллагааны зардалд тусгах
10	Химийн бодисын агуулахын барилгын хийц, инженерийн байгууламжийн төлөвлөлт, гүйцэтгэлийн доголдоос үүдэн газрын гадаргад химийн бодис алдагдах, улмаар түүний урсцаар тархаж, голдирлын дагуух усыг бохирдуулах	Химийн бодисын агуулахын барилга байгууламж нь шалыг химийн үйлчлэлд тэсвэртэй зузаан материалаар хийх боловч нэвчилт, алдагдлыг байнга шалгаж, шаардлагатай арга хэмжээг тухай бүр авч байх	Боловсруулах үйлдвэр	Урьдчилан тооцох боломжгүй Үйл ажиллагааны зардалд тусгах
11	Усан орчинд урт болон богино хугацааны хурц хоруу чанартай, усны амьд организмд хортой зэрэглэлд хамаарах бодисын хадгалалт, ашиглалтыг зохих журмын дагуу явуулаагүйгээс усан орчинд сөрөг нөлөөлөх	Зарим төрлийн химийн бодис нь усан орчинд урт болон богино хугацааны хурц хоруу чанартай, усны амьд организмд хортой зэрэглэлд хамаарах бодис тул химийн бодисын тээвэрлэлт, хадгалалтыг хор аюулын лавлах мэдээлэлд тусгасны дагуу явуулах, усан орчинд нөлөөлөл үзүүлэхээс урьдчилан сэргийлэх	Боловсруулах үйлдвэр	Урьдчилан тооцох боломжгүй Үйл ажиллагааны зардалд тусгах
12	Ахуйн бохир усыг цэвэрлэх, халдваргүйжүүлэх, бохир ус хадгалах сан байгуулаагүйгээс хөрсөнд хаягдаж бохирдол үүсгэх	Төслийн хүчин чадалд тохирсон бага оврын ахуйн бохир ус цэвэрлэх байгууламж байгуулах, ашиглах, саарал усыг замын усалгаанд эргүүлэн ашиглах боломжийг судлан нэвтрүүлэх	Цэвэрлэх байгууламж	Хөрсөн бүрхэвчид нөлөөлөх сөрөг нөлөөллийн төлөвлөгөөнд тусгагдсан
Нийт дүн				8,500.00

Хүснэгт 11. Цаг уур амьсгалын арга хэмжээ

№	Гол болон болзошгүй сөрөг нөлөөллүүд	Сөрөг нөлөөллийг арилгах, бууруулах арга хэмжээ	Хамрах хүрээ	Нэгжийн зардал /мян.төг/	Баримтлах эрх зүйн баримт бичиг
---	--------------------------------------	---	--------------	--------------------------	---------------------------------

1	Химийн бодисын хадгалалтын горим хангахгүй нөхцөлд хадгалбал хэт хөрснөөс талсжих, халснаас ууршиж дотоод даралт нэмэгдэх, дулаанд тогтворгүй бүтээгдэхүүн үүсэх, нарны гэрэл болон хэт ягаан туяанаас исэлдэх, полимержих зэргээр бүтээгдэхүүний шинж чанар өөрчлөгдөх, өндөр температурт хэт халснаас тэсэрч, дэлбэрэх, галын аюул гарах, бүтээгдэхүүний чанар өөрчлөгдөх, асарч алдагдах	Химийн бодисын агуулахын агааржуулалтын системийн ажиллагаа, агааржуулалтын хоолойн бүрэн бүтэн байдал, химийн бодисын савны болон асгарсан бодис тарахаас сэргийлсэн тосгуур, суурины зузаан, идэгдэлт, химийн бодис тавьсан тавиур болон холбоосны механик бүрэн бүтэн байдал, тавиур дээр хадгалж буй бодисын дээд хэмжээг байнгын хяналт тавихаас гадна шатамхай, онцгой хортой бодисын сав баглаа боодлыг өдөрт 1 удаа, бусад бодисыг долоо хоногт 1 удаа шалгаж хяналтыг тогтмол хугацааны давтамжтайгаар хийж, тэмдэглэл хөтөлж байх	Боловсруулах үйлдвэр	1,250.00	MNS 6458:2014, Хөдөлмөрийн аюулгүй ажиллагаа, эрүүл ахуй. Химийн хорт болон аюултай бодис, бүтээгдэхүүний агуулах. Ерөнхий шаардлага Химийн бодис тус бүрийн хор аюулын лавлах мэдээлэл /MSDS/-ийг ашиглах
2	Шингэн төлөвтэй бодисууд дулааны нөлөөгөөр тэлэх, улмаар хальж асгарах	Химийн бодисын агуулахын ажлын байр нь галд тэсвэршилтийн зэргийг хангахуйц материал, хийцтэй, болзошгүй ослын үед хөрсөнд болон гадагш бодис алдагдахааргүй шал (цементэн болон плитан), бат бэх хамгаалалт бүхий цонх, хаалгатай байхаар засаж тохижуулах	Химийн бодисын агуулах	1,000.00	MNS 6458:2014, Хөдөлмөрийн аюулгүй ажиллагаа, эрүүл ахуй. Химийн хорт болон аюултай бодис, бүтээгдэхүүний агуулах. Ерөнхий шаардлага, Химийн бодис тус бүрийн хор аюулын лавлах
3	Химийн бодис, тэсэрч дэлбэрэх бодисын хадгалах температурын өөрчлөлт, хэт их халалтаас шалтгаалан найрлага шинж чанарт өөрчлөлт орох	Химийн бодис, тэсэрч дэлбэрэх бодисын агуулахад хор аюулын лавлах мэдээлэлд тусгасны дагуу хоорондоо нийцэхгүй бодисуудыг хамт хадгалахгүй	Химийн бодисын болон тэсрэх бодисын агуулах	Урьдчилан тооцох боломжгүй	MNS 6458:2014, Хөдөлмөрийн аюулгүй ажиллагаа, эрүүл ахуй. Химийн хорт болон аюултай бодис, бүтээгдэхүүний агуулах. Ерөнхий шаардлага Химийн бодис тус бүрийн хор аюулын лавлах мэдээлэл /MSDS/-ийг ашиглах Монгол Улсын Гамшгаас хамгаалах тухай хуулийн 4.1.1, 4.1.3, 11.1; Байгаль орчны нөлөөллийн үнэлгээний тухай хуулийн 7.1.2, 8.2.8; Ашигт малтмалын тухай хуулийн 48 дугаар зүйл; Байгаль орчныг хамгаалах тухай хуулийн 6.1.2; Усны тухай хуулийн 23-25 дугаар зүйл; Онцгой байдлын тухай хуулийн 7.1 дэх заалтууд
4	Аянга цахилгаан, гэнэтийн хүчтэй цахилгаан гүйдлийн нөлөөгөөр тэсэрч дэлбэрэх		Урьдчилан тооцох боломжгүй		
5	Уурхайн хөрсний, уулын бэл, голын сав газрын усны урсацын судалгаа хийж үерийн болон бусад гамшигийн эрсдэлийн нарийвчилсан үнэлгээг эрх бүхий байгууллагаар гүйцэтгүүлж судалгаа шинжилгээ хийлгэх	Гамшгийн эрсдэлийг мэргэжлийн үнэлгээнд үндэслэн тогтоон, түүнд нийцсэн инженерийн хамгаалалт, ус зайлуулах шийдэл, эрсдэлийн удирдлага, мониторингийн систем, онцгой байдлын арга хэмжээ, нөхөн сэргээлт болон уурхайн хаалтын төлөвлөлтийг хууль тогтоомжийн дагуу хэрэгжүүлэх	Лицензийн талбай	Нөхөн сэргээлтийн зардалд туссан.	
6	Туул голд Хур тунадас, урсацын түвшин тогтмол хэмжих автомат мэдрэгч байршуулж үерийн болон эргийн байгууламжийн эрсэдэлээс урьдчилан сэргийлэх	Орон нутгийн ус зүйн мэдээлэл, олон жилийн хур тунадасны дундаж, 100 жилийн давтамжийн үерийн статистикийг ашиглан онолын болон бодит урсацын гидрологийн тооцоог хийж үерийн болон аваарын хамгаалалтын далан, суваг, шуудуу, ус	Лицензийн талбай	Орчны хяналт шинжилгээний хөтөлбөрт тусгагдсан	

7	Ил уурхайн овоолго, ажлын талбайн эргэн тойронд хөрсний далан, ус хаагуур хамгаалалт хийх	зайлуулах байгууламжийг төлөвлөж, барьж байгуулах	Лицензийн талбай	1,000.00	
8	Ажилчдад зориулсан үерийн сургалт, дадлага (drill)-ыг улирал бүр зохион байгуулах.		Лицензийн талбай	500.00	
9	Кемп, агуулах, шатахуун түгээх станц, цахилгааны дэд станцыг усанд автахаас хамгаалсан өндөрлөгт байрлуулах		Лицензийн талбай	1,000.00	
Нийт зардал				4,750.00	

Хүснэгт 12. Хүний эрүүл мэндийн арга хэмжээ

№	Гол болон нөлөөллийг сөрөг нөлөөллүүд	Сөрөг нөлөөллийг арилгах, бууруулах арга хэмжээ	Хамрах хүрээ	Нэгжийн зардал /мян.төг/	Баримтлах эрх зүйн баримт бичиг
1	Химийн бодисын агуулахын барилгын хийц, инженерийн байгууламжийн төлөвлөлт, гүйцэтгэлийн доголдлоос үүдэн аюул, осол гарах	Химийн бодисын агуулахын барилгын хийц, инженерийн байгууламжийн төлөвлөлт, гүйцэтгэлийн доголдлоос үүдэн аюул, осол гарахаас байнга урьдчилан сэргийлэх арга хэмжээ авах, агуулахын бүрэн бүтэн байдалд байнгын хяналт тавих	Боловсруулах үйлдвэр	1,000.00	Химийн хорт болон аюултай бодисын тухай хууль; Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн тухай хууль; Байгаль орчныг хамгаалах тухай хууль; Байгаль орчны нөлөөллийн үнэлгээний тухай хууль; MNS 6458:2014, Хөдөлмөрийн аюулгүй ажиллагаа, эрүүл ахуй. Химийн хорт болон аюултай бодис, бүтээгдэхүүний агуулах. Ерөнхий шаардлага
2	Мэргэжилтэн, ажилтны чадваргүй байдал, хариуцлагагүй үйлдэл, хөдөлмөр хамгаалал, аюулгүй ажиллагааг хангаж ажиллаагүйгээс ажлын байранд химийн бодис алдагдах, хүний эрүүл мэндэд нөлөөлөх	Химийн бодисын агуулахад ажиллаж буй мэргэжилтэн нь хор аюулын лавлах мэдээлэлд заасан хөдөлмөр хамгаалал, аюулгүй ажиллагааг хангаж ажиллахаас гадна химийн бодис алдагдахаас урьдчилан сэргийлсэн бүхий л арга хэмжээг авч хэрэгжүүлэх, асгарч алдагдсан тохиолдолд түүнийг саармагжуулах арга хэмжээг авах чадварыг эзэмшсэн байх	Боловсруулах үйлдвэр	700.00	Химийн бодис тус бүрийн хор аюулын лавлах мэдээлэл /MSDS/-ийг ашиглах
3	Үйлдвэрлэгчээс гаргасан хор аюулын лавлах мэдээллийг үндэслэн химийн бодис, бүтээгдэхүүн эсвэл химийн бодис хадгалах үйл ажиллагааг нэг бүрээр боловсруулж мөрдөөгүйгээс аюулгүй байдал алдагдах, хүний эрүүл мэндэд нөлөөлөх	Аюулгүй ажиллагааны зааварчилгааг өөрийн байгууллагын даргаар баглуулан ажлын байр болон агуулахад химийн бодистой харьцаж ажилладаг ажилтан өдөр тутмын ажиллагаанд ашиглаж байх боломжтой харагдахуйц газарт байрлуулах бөгөөд аюулгүй ажиллагааны зааварчилгаанд химийн бодисын хор аюул, үүсэж болох эрсдэл /хүний эрүүл мэнд, байгаль орчин/,	Боловсруулах үйлдвэр	Хөдөлмөр хамгаалал, аюулгүй ажиллагааны зардалд туссан	

		химийн бодистой харьцах, хадгалах зааварчилгаа, асгарч алдагдсан болон галын аюулын үед авах арга хэмжээ, анхны тусламж, хувийн хамгаалах хэрэгсэл, хэрэглэх заавар, хаягдлыг устгах зааварчилгааг зэргийг багтаасан байна			
4	Химийн бодисыг хамт хадгалж болохгүй бодис болон зориулалтын бус орчин, агуулахад хадгалснаас хүний эрүүл мэндэд сөрөг нөлөөлөл үзүүлэх	Ажлын байран доторх бага хэмжээтэй химийн бодис хадгалах зөөврийн агуулахыг шат, аврах гарц, хонгилын эргэлтийн өнцөг, давчуу хонгил гэх мэт хүмүүсийн хөдөлгөөнд саад учруулах эрсдэлтэй газар болон албан тасалгаа, амрах өрөө, цайны газар, биеийн тамирын өрөө, эмнэлгийн тусламжийн өрөөний ойр байрлуулах, орон сууц, худалдаа үйлчилгээний газрын болон албан байгууллагын байшингийн зoorийн давхарт хадгалахгүй байх	Боловсруулах үйлдвэр	Урьдчилан боломжгүй	тооцох
5	Химийн бодисыг тээвэрлэх, хадгалах үйл ажиллагаа нь хөдөлмөр хамгаалал, аюулгүй ажиллагааны нөхцөл, шаардлагыг бүрэн хангасан зориулалтын байр, талбай, ослын үед ажиллах арга хэмжээний төлөвлөгөөгүй ажилласнаас хүний эрүүл мэнд, эд хөрөнгө, байгаль орчинд хохирол үүсэх	Химийн хорт болон аюултай бодис тээвэрлэх, хадгалахтай холбоотой үйл ажиллагааг хөдөлмөр хамгаалал, аюулгүй ажиллагааны нөхцөл, шаардлагыг бүрэн хангасан зориулалтын байр, талбайд явуулахаас гадна болзошгүй аюул, осол гарсан үед хүний эрүүл мэнд, эд хөрөнгө, байгаль орчинд үүсэх хохирлыг бууруулах зорилгоор авч хэрэгжүүлэх үйл ажиллагаа, түүний дарааллыг тогтоосон "Аюул, ослын үед ажиллах төлөвлөгөө" боловсруулж, тухайн орон нутгийн Онцгой байдлын газраар батлуулсан хэрэгжүүлэх	Боловсруулах үйлдвэр	Хөдөлмөр хамгаалал, аюулгүй ажиллагааны зардалд туссан	
6	Химийн бодистой харьцаж ажиллах ажиллагсад нь зохих шатны сургалтад хамрагдаагүй, зохих мэдлэг дадлыг эзэмшээгүйгээс химийн бодистой харьцаж ажиллах хөдөлмөр хамгаалал, аюулгүй ажиллагааг зөрчих, хордох	Химийн бодистой харьцаж ажилладаг ажиллагсдыг үүсэж болох эрсдэлээс урьдчилан сэргийлэх, түүнийг хянах, эрсдэл үүссэн тохиолдолд хариу арга хэмжээ авах мэдлэг, дадлыг эзэмшүүлэх сургалтад заавал хамруулсан байх	Боловсруулах үйлдвэр	Хөдөлмөр хамгаалал, аюулгүй ажиллагааны зардалд туссан	
7	Химийн бодисын агуулахад хор аюулын лавлах мэдээлэлд заасан болзошгүй аюул, ослын үед ашиглах багаж хэрэгсэл, материалыг ажлын байранд байршуулж, ажиллагсдад ашиглах дадлыг эзэмшүүлээгүйгээс	Химийн бодисын агуулахын болзошгүй аюул, ослын үед ашиглах, хор аюулын лавлах мэдээлэлд заасны дагуу бүрэн ажиллагаатай гал унтраах багаж, хэрэгсэл, хор саармагжуулах бодис, уусмал, химийн бодис асгарч алдагдсан үед ашиглах багаж, хэрэгсэл, шингээгч материал, хувийн	Боловсруулах үйлдвэр		1,000.00

хүний эрүүл мэнд, байгаль орчинд хохирол учрах	хамгаалах хэрэгсэл (арьс, нүд, амьсгал хамгаалах), амьсгал хамгаалах баг, шаардлагатай тохиолдолд нүд угаах болон ослын шүршүүр зэргийг ажлын байранд байршуулж, ажиллагсад ажиллах дадлыг эзэмшүүлэх			
Нийт дүн				2,700.00

Хүснэгт 13. Удирдлага, зохион байгуулалтын арга хэмжээ

№	Гол болон болзошгүй сөрөг нөлөөллүүд	Сөрөг нөлөөллийг арилгах, бууруулах арга хэмжээ	Хамрах хүрээ	Нэгжийн зардал /мян.төг/	Баримтлах эрх зүйн баримт бичиг
1	Жил бүр дараах ажлуудыг гүйцэтгэж, холбогдох зөвшөөрлүүдийг сунгуулж, гэрээ байгуулан биелэлтийг хангаж ажиллах	Байгаль орчны менежментийн төлөвлөгөөг боловсруулан холбогдох газраар батлуулж, биелэлтийг хангах	Компанийн хэмжээнд	Үйл ажиллагааны зардалд тусгах	Байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээний тухай хууль /шинэчилсэн найруулга/
2		Ус ашиглах дүгнэлт гаргуулж, зөвшөөрөл авч, гэрээг байгуулах, гүйцэтгэлийг хангах	Компанийн хэмжээнд	Үйл ажиллагааны зардалд тусгах	Усны тухай хууль /шинэчилсэн найруулга/
3		Ус ашиглалтын мэдээ тайланг боловсруулан холбогдох газруудад хүргүүлэх	Компанийн хэмжээнд	Үйл ажиллагааны зардалд тусгах	Усны тухай хууль /шинэчилсэн найруулга/
4		Эрх бүхий байгууллагатай хамтран хог хаягдлыг тээвэрлэн, зайлуулах гэрээг хийж, гүйцэтгэлийг хангах	Компанийн хэмжээнд	Үйл ажиллагааны зардалд тусгах	Хог хаягдлын тухай хууль /шинэчилсэн найруулга/
5		Ус, газар, хог хаягдал, агаарын бохирдлын хураамжийг гэрээний дагуу төлөвлөгөөт хугацаанд барагдуулах	Компанийн хэмжээнд	Үйл ажиллагааны зардалд тусгах	Холбогдох хууль тогтоомж
6		БОХ-3 маягтыг батлагдсан маягтын дагуу бөглөж байгаль орчны мэдээллийн санд тусгуулах, бүртгүүлэх	Компанийн хэмжээнд	Үйл ажиллагааны зардалд тусгах	Газрын тухай хууль /шинэчилсэн найруулга/
7	Байгаль орчинтой холбоотой тодорхой давтамжтай хийгддэг ажлуудыг цаг тухайд нь мэргэжлийн байгууллагаар гүйцэтгүүлж байх	5 жилд нэг удаа газрын төлөв байдал, чанарын хянан баталгааг мэргэжлийн байгууллагаар гүйцэтгүүлэх	Компанийн хэмжээнд	5,000.00	Байгаль орчныг хамгаалах тухай хууль, БОАЖС-ын 2019 оны 12-р сарын 25-ны өдрийн А/809 тоот тушаал
8		2 жил тутамд байгаль орчны төлөвлөгөөт аудитын ажлыг мэргэжлийн байгууллагаар гүйцэтгүүлэх	Компанийн хэмжээнд	Байгаль орчны төлөвлөгөөт аудитын зардалд туссан.	Гамшгаас хамгаалах тухай хууль /шинэчилсэн найруулга/-ийн 7 дугаар зүйлийн 7.1 дэх хэсэг
9		Аргал ил уурхайн хэмжээнд бүхэлд нь Гамшгийн эрсдэлийн үнэлгээг Онцгой байдлын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагаас тусгай зөвшөөрөл авсан эрх бүхий мэргэжлийн	Компанийн хэмжээнд	Үйл ажиллагааны зардалд тусгах	Байгууллагын дотоод журам

		байгууллагаар хийлгэж, гамшгаас хамгаалах төлөвлөгөө боловсруулан, батлан хэрэгжүүлэх.			
10		Байгаль орчны сургалт семинарыг зохион байгуулж, түүнд хамруулах	Компанийн хэмжээнд	500.00	Байгууллагын дотоод журам
11	Байгууллага нь ажилчдын үүрэгт ажил болон байгууллагын түвшинд байгаль орчны зорилго, зорилтыг тодорхойлох	Харилцаа мэдээлэл /янз бүрийн түвшин ба ажил үүргийн хоорондын дотоод харилцаа мэдээлэл, гаднын сонирхогч талуудаас ирүүлсэн холбогдох харилцаа мэдээллийг хүлээн авах, баримтжуулах ба түүнд хариу өгөх/	Компанийн хэмжээнд	Үйл ажиллагааны зардал тусгах	Холбогдох стандарт, дүрэм, журам
12	Хяналт шалгалт	Байгаль орчны суурь нөхцөлд өөрчлөлт гарсан эсэхэд хяналт тавьж, хэмжилт хийх	Компанийн хэмжээнд	Байгаль орчны хяналт шинжилгээний хөтөлбөрт тусгагдсан	Холбогдох стандарт, дүрэм, журам
13		Байгаль орчны суурь нөхцөл нь стандарт шаардлагад нийцэж байгаа эсэхийг тодорхойлох	Компанийн хэмжээнд	Байгаль орчны хяналт шинжилгээний хөтөлбөрт тусгагдсан	Холбогдох стандарт, дүрэм, журам
14		Байгаль орчны судалгаа үнэлгээ, хяналттай холбоотой бүртгэлийн хяналт	Компанийн хэмжээнд	Байгаль орчны хяналт шинжилгээний хөтөлбөрт тусгагдсан	Холбогдох стандарт, дүрэм, журам
15		Удирдлагын дүн шинжилгээ /Байгууллагын удирдлага нь байгууллагынхаа байгаль орчны удирдлагын тогтолцооны нийцтэй, тохиромжтой, үр ашигтай байдлыг тогтмол хангахын тулд тогтоосон хугацаанд түүнд дүн шинжилгээ хийх. Эдгээр дүн шинжилгээнүүд нь байгаль орчны бодлого, зорилго, зорилтуудыг хамруулан байгаль орчны удирдлагын тогтолцоонд өөрчлөлт оруулах хэрэгцээг тодорхойлох, тогтолцоог сайжруулах боломжуудыг үнэлэх асуудлыг авч үзэх/	Компанийн хэмжээнд	2,550.00	Холбогдох стандарт, дүрэм, журам, ISO14001:2015
Нийт дүн				8,050.00	

1.3. Техникийн болон биологийн нөхөн сэргээлтийн төлөвлөгөө

Байгаль орчны нөлөөллийн нарийвчилсан үнэлгээний тайлангийн 10-р бүлэгт тус уурхайн техникийн болон биологийн нөхөн сэргээлт, ил уурхай, баяжуулах үйлдвэр, бусад барилга байгууламж, объектуудын хаалтын төлөвлөгөөг дэлгэрэнгүй боловсруулсан болно. Энэхүү менежментийн төлөвлөгөөнд төслийн 1-9 дэх жилийн техникийн болон биологийн нөхөн сэргээлтийн төлөвлөгөөг боловсрууллаа.

Хүснэгт 14. Нөхөн сэргээлтийн төлөвлөгөө /2026-2035 он/

1	ТЕХНИКИЙН БОЛОН БИОЛОГИЙН НӨХӨН СЭРГЭЭЛТ	Ил уурхайд 109.31 га Хөрсний овоолго 75.63 Ислдсэн хүдэр боловсруулах үйлдвэр, Үерийн усан сан, Аваарын усан санд нийт 70.46 га, түүнийг дагасан дэд бүтэц болох нуруулдан уусгах талбайд 66.88 га, Уурхайн хотхоны зориулалтаар 21.15 га, Тэсрэх материалын агуулах 4.62 га, Шатахуун түгээх станц 1.96 га, Уурхайн засварын талбайд 17.07 га, Технологийн замд 7.97 га, шимт хөрсний овоолго 6.71 га талбай , нийт 259.11 га талбай эвдрэлд өртөнө.	Техникийн нөхөн сэргээлтийн хөрсний овоолгод 492.98 мян.м ³ , Биологийн нөхөн сэргээлтэд шимт хөрсөөр хучихад 260.45 мян.м ³ газар шорооны ажил хийгдэх бөгөөд ургамалжуулалт хийх талбай хэмжээ 225.44 га байна. Нөхөн сэргээлтийн ажлыг төслийн 8 дах жилээс эхлэн хийх бөгөөд нийт 492,98 мян.м ³ ажил хийнэ. Нуруулдан уусгах байгууламжийн нөхөн сэргээлтийн ажлыг 9 дэх жилд хийхээр төлөвлөсөн ба нийт 150.91 м ³ ажил хийж гүйцэтгэнэ. Шимт хөрсний овоолгыг 7-8 жил хадгалах шаардлага гарч байгаа тул шимт хөрсний хадгалалт, хамгаалалт, арчилгаа тордолгооны менежментийн хөтөлбөрийг боловсруулан, ажиллах шаардлагатай. Тиймээс нөхөн сэргээлтийн зардлыг жил бүр хуримтлуулах шаардлагатай.	2026-2035 он	1 дэх жил	279.6	Ашиглалтын нийт хугацаанд 41,557.50.0	MNS 5914:2008 Байгаль орчин. Газрын нөхөн сэргээлт. Нөхцөл болзол ба тодорхойлолт MNS 5915:2008 Байгаль орчин. Уурхайн үйл ажиллагааны улмаас эвдэгдсэн газрын ангилал MNS 5916:2008 Байгаль орчин. Үржил шимтэй хөрсийг зайлуулахад тавигдах шаардлага ба хөрсийг ухах хугацаанд түр хадгалах MNS 4920:2000 Байгаль орчин. Эвдэгдсэн газрын налуу. Техникийн шаардлага MNS 5917:2008 Байгаль орчин. Уурхайн үйл ажиллагааны улмаас эвдэгдсэн газрыг нөхөн сэргээх. Техникийн ерөнхий шаардлага MNS 4920:2000 Байгаль орчин. Элдэгдсэн газрын налуу. Техникийн шаардлага MNS 5918:2008 Байгаль орчин. Эвдэгдсэн газрын ургамлыг нөхөн сэргээх. Техникийн ерөнхий шаардлага
					2 дэх жил	255		
					3 дэх жил	259.7		
					4 дэх жил	517.4		
					5 дэх жил	459.4		
					6 дэх жил	1,746.10		
					7 дэх жил	1,750.40		
					8 дэх жил	18,267.70		
					9 дэх жил	18,022.20		
НИЙТ ЗАРДАЛ			-	41,557.50				

1.4. Биологийн олон янз байдлыг дүйцүүлэн хамгаалах төлөвлөгөө

Аргал нэртэй талбайн алтны үндсэн ордыг ашиглах төслийн Дүйцүүлэн хамгаалах арга хэмжээний ажлыг гүйцэтгэхэд эхний жилийн 6,000,000.0 (Зургаан сая) төгрөг зарцуулах тооцоолол гарч байна. Доорх хүснэгтэд төлөвлөгдсөн ажлын дэлгэрэнгүйг хугацаа, зардал, ажлын төрлөөр нэг бүрчлэн харууллаа.

Хүснэгт 15. Дүйцүүлэн хамгаалах арга хэмжээний төлөвлөгөө, /2026 он/

№	Нөхөн сэргээлтийн зорилго	Дүйцүүлэн хамгаалах арга хэмжээний зорилт	Дүйцүүлэн хамгаалах арга хэмжээ	Оролцогч талууд	Дүйцүүлэн хамгааллын байршил	Нийт зардал /мян.төг/
1	ДҮЙЦҮҮЛЭН ХАМГААЛАХ АРГА ХЭМЖЭЭНИЙ	Туул голын экосистемийг сайжруулах	Усны чанар болон бусад цогц судалгаа, мониторинг хийх зориулалттай харуул бий болгох	Туул голын сав газрын захиргаа, ЦУОШГ	Туул гол	5,000.0
2		Ховор амьтдын мониторинг судалгаа хийх	Аргалийн нурууны халиун буга, аргаль хонины мониторинг судалгааг тогтмол автомат камерын болон хос ажиглагчийн аргаар явуулах	Лүн сумын БО-ны хэлтэс, мэргэжлийн байгууллага	Аргалийн нуруу	-
3		Амьтны амьдрах орчныг сайжруулах	Өвлийн улиралд биотехникийн арга хэмжээ авч хэрэгжүүлэх	Лүн сумын БО-ны хэлтэс, мэргэжлийн байгууллага	Аргалийн нуруу	1,000.0
4		Ховор амьтдыг сэлгэн нутагшуулах хөтөлбөр хэрэгжүүлэх	Төслийн талбайн нөлөөлөлд өртөх зарим хэсэгт тархсан 20 орчим толгой монгол тарвагыг холбогдох хууль эрх зүйн хүрээнд сэлгэн нутагшуулах	Лүн сумын БО-ны хэлтэс, мэргэжлийн байгууллага	Аргалийн нуруу	-
5		Халиун буга хамгаалал	Аргалийн нуруунд тархсан халиун бугын популяцид уурхайн үйл ажиллагаанаас үзүүлж буй нөлөөллийг үнэлэх зорилгоор сансрын дамжуулагч бүхий хүзүүвч зүүх	Лүн сумын БО-ны хэлтэс, мэргэжлийн байгууллага	Аргалийн нуруу	-
6		Эвдэрч орхигдсон газар нөхөн сэргээх	Лүн сумын нутагт 12 байршилд 29.34 га талбайгаас сумын ЗДТГ-тай зөвшилцөн жил бүрийн БОМТ-д тусган нөхөн сэргээх	Лүн сумын БО-ны хэлтэс, мэргэжлийн байгууллага	Эвдэрсэн газар	-
НИЙТ ЗАРДАЛ						6,000.0

1.5. НҮҮЛГЭН ШИЛЖҮҮЛЭХ, НӨХӨН ОЛГОВОР ОЛГОХ ТӨЛӨВЛӨГӨӨ

Хүснэгт 16. Нүүлгэн шилжүүлэх, нөхөн олговор олгох арга хэмжээний төлөвлөгөө, /2026 он/

№	Нөхөн	Нөлөөлөлд өртөх иргэд	Нүүлгэн шилжүүлэх арга хэмжээ	Арга хэмжээний цар, хэмжээ	Нийт зардал /мян.төг/	Хэрэгжүүлэх хугацаа ба давтамж

сэргээлтийн зорилго						2026 он	
1	ДҮЙЦҮҮЛЭН ХАМГААЛАХ АРГА ИЙНЭЖМЭХ	Лицензийн талбайд давхцалтай малчин айл өрх	Лицензийн талбайд давхцалтай айл өрхтэй хамтран "Нүүлгэн шилжүүлэх, нөхөн олговор олгох төлөвлөгөө" боловсруулан хэрэгжүүлэх	Лицензийн талбайд давхцалтай айл өрх	Урьдчилан тооцох боломжгүй	Үйл ажиллагааны туршид	Газрын тухай хууль, Ашигт малтмалын тухай хуулийн 39, 40 дүгээр зүйл
		Уурхайн болон үйлдвэрлэлийн үйл ажиллагаанд дам нөлөөлөлд өртөх айл өрх, иргэн, аж ахуй нэгж, байгууллага	Нийгмийн хариуцлагын гэрээг Лүн сумын Засаг даргатай байгуулах, Орон нутгийн хөгжлийн хөтөлбөр боловсруулж хэрэгжүүлэх	Дам нөлөөлөлд өртөх айл өрх, иргэн аж ахуй нэгж байгууллага	Үйл ажиллагааны зардалд тусгах	Үйл ажиллагааны туршид	
НИЙТ ЗАРДАЛ						5,000.000	

1.6. ТҮҮХ СОЁЛЫН ӨВИЙГ ХАМГААЛАХ ТӨЛӨВЛӨГӨӨ

Хүснэгт 17. Түүх соёлын өвийг хамгаалах арга хэмжээний төлөвлөгөө, /2026 он/

№	Нөлөөлөлд өртөх түүх, соёлын өв	Хамгаалах арга хэмжээ	Арга хэмжээний цар, хэмжээ	Нийт зардал, /төг/	Баримтлах эрх зүйн баримт бичиг
1	Археологийн дурсгал	Уурхайн үйл ажиллагааны явцад түүх, соёлын өв, археологийн олдвор илэрсэн тохиолдолд ажлыг нэн даруй зогсоож, талбайг хамгаалан тэмдэглэж, холбогдох мэргэжлийн байгууллагуудад мэдэгдэн археологийн үнэлгээ хийлгэж, шийдвэрийн дагуу дараагийн арга хэмжээг хэрэгжүүлнэ.	Лицензийн талбай	3,500.000	Соёлын өвийг хамгаалах тухай хууль; Байгаль орчны нөлөөллийн үнэлгээний тухай хууль; Байгаль орчныг хамгаалах тухай хууль; Ашигт малтмалын тухай хуулийн 39, 40 дүгээр зүйл; холбогдох дүрэм,
2	Палеонтологийн дурсгал				
НИЙТ ЗАРДАЛ				3,500.000	

1.7. ОСОЛ, ЭРСДЭЛИЙН МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ

Энэ төлөвлөгөөнд батлагдсан аргачлалын дагуу хийсэн байгалийн аюул, гамшгийн үнэлгээгээр тогтоогдсон учирч болзошгүй байгалийн гамшиг, түүнээс урьдчилан сэргийлэх чиглэлээр авч хэрэгжүүлэх арга хэмжээ, шаардагдах зардал, баримтлах стандартыг энд тусгасан.

Хүснэгт 18. Осол эрсдлийн менежментийн төлөвлөгөө, /2026 он/

№	Хамрах хүрээ	Болзошгүй аюул, осол, сөрөг нөлөөлөл	Урьдчилан сэргийлэх, хамгаалах арга хэмжээ	Нийт зардал, төг
1	ОСОЛ, ЭРСДЭЛИЙН МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ	Мэргэшиж дадаагүй ажилчдыг удирдлагын заавар, зөвшөөрөлгүй, бусдын гуйлт хүсэлтээр буюу дур мэдэн ажил гүйцэтгэснээс болж осол аваар гарах	Мэргэшиж дадаагүй ажилчдыг удирдлагын заавар, зөвшөөрөлгүй, бусдын гуйлт хүсэлтээр буюу дур мэдэн ажил гүйцэтгүүлэхгүй байх, осол аваар гарахаас урьдчилан сэргийлэх	Урьдчилан тооцох боломжгүй
2		Өндөр хүчдэл, цахилгаан тоног төхөөрөмжтэй ажиллаж буй хүн нь хөдөлмөр хамгааллын дүрэм зөрчих, багаж хэрэгсэл, хамгааллын хувцасгүй ажилласнаас осолд өртөх, үхэлд хүрэх	Өндөр хүчдэл, цахилгаан тоног төхөөрөмжтэй харьцан ажиллаж буй хүнийг багаж хэрэгсэл, хамгааллын хувцсаар бүрэн хангах, хөдөлмөр хамгаалал, аюулгүй ажиллагааны дүрмийг чанд мөрдүүлэн ажиллах	Урьдчилан тооцох боломжгүй
3		Чийгтэй орчинд цахилгаан тоног төхөөрөмж, өндөр хүчдэлтэй харьцан ажиллавал богино холбоо үүсэх, осолд өртөх	Чийгтэй орчинд цахилгаан тоног төхөөрөмж, өндөр хүчдэлтэй харьцан ажиллавал богино холбоо үүсэх эрсдэлтэй тул урьдчилан сэргийлэх үүднээс хур тунадас, чийгтэй үед ажилчдыг ажиллуулахгүй байх	Урьдчилан тооцох боломжгүй
4		Цахилгаан хэрэгслийн хүчдэлийг салгалгүй засвар үйлчилгээ хийж хүчдэлд цохиулах	Цахилгаан хэрэгслийн хүчдэлийг салгалгүй засвар үйлчилгээ хийж хүчдэлд цохиулахаас байнга урьдчилан сэргийлэх	Урьдчилан тооцох боломжгүй
5		Цахилгаан тоног төхөөрөмжид байнгын үзлэг үйлчилгээ хийгээгүй, ашиглалтын заавар зөрчих	Цахилгаан тоног төхөөрөмжид байнгын үзлэг үйлчилгээ хийх, ашиглалтын заавар зөрчихгүй байх	Урьдчилан тооцох боломжгүй
6		Аюулгүйн зайлшгүй буюу мэдээжийн арга хэмжээ авалгүй эсвэл аваагүй байхад ажилд яаравчлан орох	Аюулгүйн зайлшгүй буюу мэдээжийн арга хэмжээ авалгүй эсвэл аваагүй байхад ажилд яаравчлан орохгүй байх, хөдөлмөр хамгаалал аюулгүй ажиллагааны дүрэм, зааврыг мөрдөн ажиллах	Урьдчилан тооцох боломжгүй
7		Технологийн хэвийн ажиллагааны горим алдагдаж тоног төхөөрөмжүүдэд эвдрэл, доголдол гарах	Уурхайн цахилгаан тоног төхөөрөмж, өндөр хүчдэл зэрэгтэй харьцан ажиллаж буй хүн мэргэжлийн хүн байх, мэргэжлийн бус хүн түүгээр оролдох, харьцаж ажиллахыг хатуу хориглох	Урьдчилан тооцох боломжгүй
НИЙТ ЗАРДАЛ				4,000.000

1.8. ХОГ ХАЯГДЛЫН МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ

Тус байгууллага нь Хог хаягдлын тухай (шинэчилсэн найруулга) хууль, Аюултай хог хаягдлыг түр хадгалах, цуглуулах, тээвэрлэх, дахин боловсруулах, устгах болон бүртгэх, тайлагнах журам зэрэг хог хаягдлын талаар заасан **аж ахуйн нэгж, байгууллагын эрх, үүргийг биелүүлэн ажиллах шаардлагатай.**

Хүснэгт 19. Хог хаягдлын менежментийн төлөвлөгөө

№	Хамрах хүрээ	Хог хаягдлын ангилал	Сөрөг нөлөөллийг арилгах, бууруулах арга хэмжээ	Нэгжийн зардал, /мян.төг/
1	ХОГ ХАЯГДЛЫН МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ	Ахуйн хог хаягдал	Энгийн хог хаягдлаа ангилан ялгах, хог хаягдлын цэгийг стандарт шаардлагын дагуу байгуулах, шаардлага хангасан ангилан ялгах хогийн сав байршуулах	1,500.00
2			Хог хаягдал цуглуулах, тээвэрлэх эрх бүхий аж ахуйн нэгж, байгууллагатай хог тээврийн үйлчилгээний гэрээ байгуулах, үүссэн хог хаягдлаа тогтмол зайлуулах	1,000.00
3		Үйлдвэрийн хог хаягдал	Барилга барих, буулгах, засварлах үйл ажиллагаанаас гарах хог хаягдлыг цуглуулах, тээвэрлэх, дахин боловсруулах, устгах, булшлахдаа эрх бүхий аж ахуйн нэгж, байгууллагад шилжүүлэх, устгах	1,000.00
4			Ажилчдад хог хаягдлыг бууруулах, ангилах, дахин ашиглах, зүй зохистой хаях дадал зуршлыг хэвшүүлэх, сургалт зохион байгуулах	500.00
5			Үүсэх хог хаягдлыг ангилан ялгах, хог хаягдал цуглуулах, тээвэрлэх, дахин боловсруулах, сэргээн ашиглах, шатаах, устгахдаа үйл ажиллагаатай холбоотой гэрээ байгуулах, гэрээний хэрэгжилтэд хяналт тавих	Урьдчилан тооцох боломжгүй
6			Аюултай энгийн хогтой хольж хутгахгүй байх	500.00
7			Аюултай хог хаягдлыг Бетон суурьтай, асгаралт нэвтрэхгүй, ус чийг тусгаарласан, салхи хаалттай, галын аюулгүй байдалтай агуулахад хадгалах	500.00
8		Аюултай хог хаягдал	“Аюултай хаягдал – Зөвшөөрөлгүй нэвтрэхийг хориглоно” гэсэн анхааруулах самбар байрлуулах.	500.00
9			Аюултай хаягдлыг бүртгэлжүүлж, хяналтын журнал хөтлөх, Зөвхөн тусгай зөвшөөрөлтэй ААН-аар тээвэрлүүлэх, Зөвхөн тусгай зөвшөөрөл бүхий хог хаягдал боловсруулагч/устгагч ААН-д хүлээлгэн өгөх.	8,500.00
НИЙТ ЗАРДАЛ				12,500.000

1.9. ОРЧНЫ ХЯНАЛТ ШИНЖИЛГЭЭНИЙ ХӨТӨЛБӨР

Байгаль орчны хяналт шинжилгээний хөтөлбөр нь үйлдвэрийн байгаль орчинд үзүүлэх сөрөг нөлөөлөл болон агуулахыг ашиглах явцад гарч болзошгүй эрсдэлийн үед байгаль орчинд бий болох бохирдол, доройтлыг тодорхойлох зорилготой заавал хэрэгжүүлэх баримт бичиг юм. Хяналт шинжилгээний хөтөлбөрт төслийн нөлөөлөлд өртөх орчин тус бүрийг хянах гол үзүүлэлтүүд, хяналт шинжилгээ хийх давтамж, шинжлэх арга, дээж авах, хадгалах, тээвэрлэх шинжлэхэд баримтлах стандарт шаардлага зэргийг багтаасан болно. Байгаль орчны хяналт шинжилгээний хөтөлбөрийг хэрэгжүүлэхдээ энд заагдсан бохирдуулах эх үүсвэрүүдийг хянах Монгол Улсын хууль тогтоомж, стандартчилагдсан арга зүйн хязгааруудыг баримтлах шаардлагатай ба дээрх эрх зүйн актууд, стандартууд шинэчлэгдвэл түүний шинэчилсэн хувилбарыг мөрдөж ажиллах ёстой. Байгаль орчны хяналт шинжилгээний хөтөлбөрийг хэрэгжүүлж үр дүнг нь доорх асуудлуудыг тодорхойлох, үнэлэхэд ашиглана. Үүнд:

- ✓ Анх таамагласан сөрөг нөлөөллүүдийн хэмжээ, үр дагавраас бодит сөрөг нөлөөлөл, түүний үр дагавар хир зөрж байгааг,
- ✓ Байгаль орчныг хамгаалах төлөвлөгөөний хэрэгжилт болон холбогдох эрх зүйн баримт бичиг, стандарт, дүрэм журамтай нийцэж байгаа эсэхийг,
- ✓ Нөлөөллүүдийн эрчим, буурах эсвэл ихсэж байгааг,
- ✓ Төслийн байгаль орчныг хамгаалах төлөвлөгөөний нийт үр ашгийг үнэлэх зэрэг орно.

Байгаль орчны хяналт шинжилгээний хөтөлбөрийн хэрэгжилт, үр дүн, түүнд хийсэн дүгнэлт зэргийг жил бүрийн 11 дүгээр сарын дотор тухайн орон нутгийн байгаль орчны хяналтын улсын байцаагч, Иргэдийн төлөөлөгчдийн хурал, Байгаль орчин, ногоон хөгжлийн яаманд хүргүүлж хянуулан, дараа оны Байгаль орчны хяналт шинжилгээний хөтөлбөрийг батлуулах ёстой.

Манай байгууллага нь БОННУ боловсруулахдаа нуруулдан уусгалтын талбайн мониторингийн цэг нь газрын гадаргаас хамааруулж нуруулдан уусгалтын талбайн доор 1-2 цэг мөн харьцуулалт хийх зорилгоор нуруулдан уусгалтын талбайн дээр буюу эрүүл гэж үзэх боломжтой 1 цэгт хяналтын цооногийг байршуулахыг санал болгосон.

Үйлдвэр орчимд усны хяналтын цооног, өнгөн хөрсөн бүрхэвчийн мониторинг, ургамлын нөмрөгийн элэгдэл, талхагдлын байдал, агаарын чанарыг хянах зорилгоор талбайн хойд, баруун, зүүн талд тус бүр 1, урд буюу газрын хэвгий талдаа 1 цэг, нийтдээ 10 гаруй цэгийг сонгон санал болгосон.

Эдгээр цэг дээр нэмэлтээр үйлдвэрийн бүс дотор химийн бодисын агуулах, бутлуурын цехийн тоос их буудаг талбай, ахуйн хог хаягдлын цэг, засварын газрын зогсоол зэрэг объектуудтай ойролцоо цэгүүд сонгож болно.


Мөн цианидтай харьцах ажилтнуудад хувийн цианид детектортой байх нь зүйтэй бөгөөд циант устөрөгчийн хэмжээ хүлцэх хэмжээнээс хэтэрсэн тохиолдолд дохио өгдөг. Эдгээр зөөврийн агаар дахь цианит устөрөгчийн хэмжээг тодорхойлох багажуудын хэвийн ажиллагааг хангаж тогтмол хугацаанд хөндлөнгийн тохируулга хийх нь зүйтэй.

Төслийн ашиглалтын үед хаягдал чулуулгийн овоолгоос хүчиллэг урсац үүсэх эсэхэд урьдчилсан үнэлэлт өгөх судалгааны ажлыг зайлшгүй гүйцэтгэх шаардлагатай.

Аргалийн нуруу нь халиун буга, монгол тарвага, аргаль хонины тархац, байршил нутаг тул эдгээр зүйлүүдийг харууц цэг, шугаман замнал, автомат камерын аргаар тогтмол хянах, төслийн үйл ажиллагаанаас үүдэн амьдрах орчноосоо дайжсан тохиолдолд дагаж очих замаар дүйцүүлэн хамгаалах шаардлагатай.

Ховор ургамал буюу хуурамч хонин арцны тархалтыг аль болох хөндөхгүй байх, зайлшгүй хөндөх тохиолдолд түүнийг үрээр, эсвэл мөчрийн аргаар сэлгэн тарималжуулах хөтөлбөр хэрэгжүүлэх нь зүйтэй.

Байгаль орчны хяналт шинжилгээний хөтөлбөрийг холбогдох хууль, журмын дагуу явуулахаас гадна хөндлөнгийн мэргэжлийн байгууллага, магадлан итгэмжлэгдсэн лабораториуд хөрс, усны шинжилгээг тогтмол хийлгэхээс гадна нутгийн иргэд, орон нутгийн төрийн захиргааны байгаль орчны хэлтэстэй хамтарсан мониторинг хөтөлбөр боловсруулж хэрэгжүүлэх нь илүү үр дүнтэй байна.



Зураг 2. Орчны хяналт шинжилгээний хөтөлбөр хэрэгжүүлэх байршил, төрөл

Орчны хяналт шинжилгээг төслийн үйл ажиллагаатай уялдуулж төлөвлөх нь чухал бөгөөд салхины дээд талд, ямар нэгэн нөлөөлөл илрэхгүй цэгийг сонгож хөрс, агаарын чанарын хэмжилтийг хийх нь байгалийн фон өгөгдөл болно. Үүний дараагаар сөрөг нөлөөлөл үзүүлэх гол объектууд болох баяжуулах үйлдвэр, нуруулдан уусгах талбай, ажилчдын суурин, тэсрэх материалын агуулах, дотоод болон гадаад тээврийн зам дагуу хөрс, ургамал, агаарын чанарын цэгүүдийг байрлуулж өгсөн. Гадаргын болон гүний усны хувьд Туул гол дагуу төслөөс дээш, дунд, доод гэсэн 3 байршлыг санал

болгож байгаа бол газрын доорх усны мониторингийг хийхдээ баяжуулах үйлдвэр, нуруулдан уусгах талбайн доод талд 300 м, 500 м, 1000 м гэх мэт зайд хяналтын цооног гаргаж нийт болон чөлөөт цанидын хяналтыг хийхээр тусгасан. Мөн нуруулдан уусгах талбайн газрын хэвгий талд хуурай цооног өрөмдөж чийг мэдрэгч суурилуулах хэрэгцээ шаардлага байна.

Хүснэгт 20. Санал болгож буй орчны хяналт шинжилгээний газар зүйн солбицол, нэр

№	Өргөрөг	Уртраг	Шинжилгээний төрөл	Байршлын нэр
1	47.95891	104.84338	Агаарын чанар	Байгалийн суурь түвшин тогтоох
2	47.96181	104.94024	Агаарын чанар	Баяжуулах үйлдвэр
3	47.97464	104.93772	Агаарын чанар	Нуруулдан уусгах талбай
4	47.97607	104.94876	Агаарын чанар	Ажилчдын суурин
5	47.97536	104.96213	Агаарын чанар	Зам дагуу
6	48.02737	104.95261	Агаарын чанар	Тэсрэх материалын агуулах
7	48.00661	104.95499	Усны чанар	Хайгуулын кемпийн худаг
8	47.97587	104.95234	Усны чанар	Цэвэршүүлсэн ус
9	47.9935	104.92521	Усны чанар	Малчны гар худаг
10	47.93699	104.94237	Усны чанар	Туул гол
11	47.95891	104.84338	Хөрсний чанар	Байгалийн суурь түвшин тогтоох
12	47.96181	104.94024	Хөрсний чанар	Баяжуулах үйлдвэр
13	47.97464	104.93772	Хөрсний чанар	Нуруулдан уусгах талбай
14	47.97348	104.94914	Хөрсний чанар	Ажилчдын суурин
15	47.97142	104.96082	Хөрсний чанар	Хогийн цэг
16	47.97536	104.96213	Хөрсний чанар	Зам дагуу
17	48.02737	104.95261	Хөрсний чанар	Тэсрэх материалын агуулах
18	47.99161	104.9488	Ургамал	Ургамлын төрөл, зүйл, тусгаг бүрхэц
19	47.99967	104.9247	Ургамал	
20	48.0097	104.9211	Ургамал	
21	48.02358	104.946	Ургамал	
22	48.03392	104.9589	Ургамал	
23	48.03744	104.95419	Амьтан	Аргаль, буга, тарвага болон бусад
24	47.98913	104.89682	Амьтан	Буга, цагаан зээр болон бусад

Хүснэгт 21. Орчны хяналт шинжилгээний хөтөлбөр, (2026 он)

№	Хамрах хүрээ	Хяналт шинжилгээ хийх үзүүлэлтүүд	Хяналтын цэгийн байршил	Хугацаа ба давтамж	Нэгжийн зардал, /мян.төг/
1	АГААРЫН ЧАНАР	Ялгарах бохирдуулагчид: SO ₂ , CO, NO ₂	Агаарын чанарын мониторингийн цэгүүд	Сар бүр	3,000.0
2		Тоосны хэмжилт: PM ₁₀ , PM _{2.5} , Тоосны чөлөөт уналт, тоосны тархалт	Агаарын чанарын мониторингийн цэгүүд		
3		Синилийн хүчил (HCN)	Боловсруулах үйлдвэр, НУБ		
4		Ялгарах бохирдуулагчид: SO ₂ , CO, NO ₂	Уурын зуухнаас гарах утааны мониторинг		
5	ХӨРСӨН БҮРХЭВЧ	Хөрсний химийн ерөнхий шинж чанар, органикийн агууламж	Хөрсөн бүрхэвчийн мониторингийн цэгүүд	Сар бүр	3,000.0
6		Хүнд металлууд		Сар бүр	
7		Синилийн хүчил (HCN)	Боловсруулах үйлдвэр, НУБ	-	
8		Нефтийн бүтээгдэхүүн	ШТС орчимд	-	
9		Хаягдал чулуулгийн хүчил үүсгэх чадварын шинжилгээ	Хаягдал хөрсний овоолго, олборлолтын блокуудад	-	
10	УСНЫ ЧАНАРЫН МОНИТОРИНГ	Усны ерөнхий химийн шинжилгээ	Эх үүсвэрийн болон усны хяналтын цооног	Сар бүр	4,000.0
11		Газрын доорх усны хүнд металлын шинжилгээ		Сар бүр	
12		Цооногийн гүний усны түвшний хэмжилт		Сар бүр	
13		Газрын доорх усан дах Синилийн хүчил (HCN)	Үйлдвэрийн орчимд орших цооног, Туул гол	-	
14		Бохир усны шинжилгээ	Цэвэрлэх байгууламжийн оролт гаралт	Улирал тутам	
15		Микробиологийн шинжилгээ	Унд ахуй худаг, усны машин, усны нөөцийн сав, цоргуудад	Сар бүр	
16	БИОЛОГИЙН ОЛОН ЯНЗ БАЙДАЛ	Усны экологи, урсац-чанарын судалгаа	Туул гол	-	5,000.0
17		Ургамлан нөмрөгийн судалгаа	Лицензийн талбай	Жил 2 удаа	
18		Зэрлэг амьтны мониторинг	Аргалийн нуруу	Сар бүр	
19		Нугалмайтан амьтны судалгаа	Туул гол	-	



Төв аймгийн Лүн сумын нутаг дэвсгэрт орших MV-023049 дугаартай,
Аргал нэртэй "Алтны үндсэн орд ашиглах" төслийн Байгаль орчны
менежментийн төлөвлөгөө

20	ОРЧНЫ ХИМИ, ФИЗИК ҮЗҮҮЛЭЛТҮҮД	Дуу шуугиан ба доргион чичиргээн.	Бутлуур, Үйлдвэр орчимд	Сар бүр	3,000.0
НИЙТ ЗАРДАЛ					18,000.00



Хаяг: М-Плаза 13 давхар, Чингэлтэй дүүрэг, 5-р хороо,
Ч.Самбуугийн гудамж. Улаанбаатар 15141, Монгол улс
Гар утас: +976-77775757, +976-80003683
Мэйл: Dorjsambuu.g@altgana.mn

1.10. БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ ТҮҮНИЙ ХЭРЭГЖИЛТИЙГ ОРОЛЦОГЧ, СОНИРХОГЧ ТАЛУУДАД ТАЙЛАГНАХ, ХЭЛЭЛЦҮҮЛЭХ ХУВААРЬ

Төсөл хэрэгжүүлэгч жил бүр Байгаль орчны менежментийн төлөвлөгөөний хэрэгжилтийн талаар БОУАӨЯ-д тайлан хүргүүлэх ба байгаль орчны хяналтын улсын байцаагч, орон нутгийн байцаагч, бүх шатны Засаг дарга, байгаль орчны төрийн бус байгууллагад тухайн жилийн байгаль орчны менежментийн төлөвлөгөөний хэрэгжилтийн тайланг хагас жил тутамд хүргүүлнэ. Мөн Байгаль орчны менежментийн төлөвлөгөөний хэрэгжилтийн талаар танилцуулгыг хагас жил тутамд хийнэ.

Хүснэгт 22. Тухайн жилийн байгаль орчныг хамгаалах төлөвлөгөөний биелэлтийг нөлөөллийн бүсийн оршин суугчдад тайлагнах төлөвлөгөө

№	БОМТ хэрэгжилтийг тайлагнах, хэлэлцүүлэх байгууллагууд	Тайлагнах, хэлэлцүүлэх хэлбэр	Мэдээллийн агуулга	Хугацааны тов	Хэлэлцүүлгээр санал авах чиглэл	Хариуцах эзэн
1.	Төрийн захиргааны төв байгууллага (БОУАӨЯ)	БОМТ тайланг төлөвлөгөөнд тусгасан арга хэмжээний дагуу гаргаж, дараа оны БОМТ-ний төсөлтэй хамтатган ерөнхий үнэлгээ хийсэн байгууллагад хүргүүлнэ.	Байгаль орчны менежментийн төлөвлөгөөний биелэлтийн тухай	Жил бүрийн 12 дугаар сарын 10-ны дотор	Байгаль орчны менежментийн төлөвлөгөөний хэрэгжилтийн тайланг тайлагнах, батлуулах	Төсөл хэрэгжүүлэгч
2.	Төсөл хэрэгжих нутаг дэвсгэрийн сум багийн иргэдийн төлөөлөгчдийн хурал	БОМТ тайланг төлөвлөгөөнд тусгасан арга хэмжээний дагуу гаргаж, иргэдийн төлөөлөгчдийн хурлаар оруулж танилцуулах	Байгаль орчны менежментийн төлөвлөгөөний биелэлтийн тухай	Жил бүрийн 11 дүгээр сарын 10-ны дотор	Байгаль орчны менежментийн төлөвлөгөөний хэрэгжилтийг тайлагнаж олон нийтэд таниулж санал авах	Төсөл хэрэгжүүлэгч
3.	Төсөл хэрэгжих нутаг дэвсгэрийн бүх шатны Засаг дарга	БОМТ тайланг төлөвлөгөөнд тусгасан арга хэмжээний дагуу гаргаж тайланг хүргүүлэх	Байгаль орчны менежментийн төлөвлөгөөний биелэлтийн тухай	Жил бүрийн 11 дүгээр сарын 10-ны дотор	Байгаль орчны менежментийн төлөвлөгөөний хэрэгжилтийг тайлагнаж олон нийтэд таниулж санал авах	Төсөл хэрэгжүүлэгч

11.11. БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ ЗАРДЛЫН НЭГДСЭН ДҮН

Аргал алтны үндсэн ордод 2026 онд хэрэгжүүлэх Байгаль орчны менежментийн төлөвлөгөөнд зарцуулах нийт зардлыг нэгтгэн дараах хүснэгтэд үзүүлэв.

Хүснэгт 23. Байгаль орчны менежментийн төлөвлөгөөний зардлын нэгдсэн дүн

№	Үзүүлэлт	Хэмжих нэгж	Нийт дүн
1	Сөрөг нөлөөллийг бууруулах арилгах арга хэмжээний төлөвлөгөө	мян.төг	47,950.00
2	Техникийн болон биологийн нөхөн сэргээлт	мян.төг	Ашиглалтын хугацааны 8-9 дахь жилээс нөхөн сэргээлт эхлэх хийгдэх бөгөөд нийт 41,557.50.0 мян.төг зарцуулна.
3	Түүх соёлын өвийг хамгаалах төлөвлөгөө	мян.төг	3,500.00
4	Дүйцүүлэн хамгааллын төлөвлөгөө	мян.төг	6,000.00
5	Нүүлгэн шилжүүлэх, нөхөн олговор олгох төлөвлөгөө	мян.төг	5,000.00
6	Осол, эрсдэлийн менежментийн төлөвлөгөө	мян.төг	4,000.00
7	Хог, хаягдлын менежментийн төлөвлөгөө	мян.төг	12,500.00
8	Байгаль орчны хяналт шинжилгээний хөтөлбөр	мян.төг	18,000.00
9	Тэрбум мод үндэсний хөдөлгөөний хүрээнд ойн зурвас, мод үржүүлгийн талбай бий болгох,	мян.төг	15,000.00
БҮГД ДҮН		мян.төг	111,950.00

Төв аймаг аймгийн Лүн сум сумын нутагт орших “Аргал алтны үндсэн ордыг ил аргаар ашиглах, исэлдсэн хүдрийг нуруулдан уусгах аргаар баяжуулах үйлдвэрийн төслийг хэрэгжүүлэх явцад Сөрөг нөлөөллийг бууруулах арилгах арга хэмжээний төлөвлөгөөнд эхний жил **47.950 сая** төгрөг, Хог хаягдлын менежментийн төлөвлөгөөнд эхний жил **12.5 сая** төгрөг, Байгаль орчны хяналт шинжилгээний хөтөлбөрт жил бүр **18.0 сая.төг**, байгаль орчны аудитыг 2026 онд хийгдэхгүй, Тэрбум мод үндэсний хөдөлгөөний хүрээнд мод үржүүлгийн талбай бий болгохоор **15.0 сая төгрөг**, үйл ажиллагаа явуулах эхний жилийн хугацаанд Байгаль орчны менежментийн төлөвлөгөөнд нийт **96.95 сая.төг** зарцуулахаар төлөвлөв.

Ашигласан веб сайтын жагсаалт

1. www.1212.mn
2. www.tuv.nso.mn
3. www.tuv.tsag-agaar.gov.mn
4. www.tsag-agaar.gov.mn